# ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНД УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ ЭРХЛЭХ АСУУДЛААР ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТЭД 2022 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН БАЙДЛААР ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА

2022 оны 06 дугаар сарын 29-ний өдөр

## Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд салбарын асуудлаар тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийж, үйл ажиллагааны гүйцэтгэлийг тухайн жилд тавьсан зорилтыг хүрэх түвшинтэй нь харьцуулан, хэрэгжилтийн түвшинг тогтоох, үр дүнг үнэлэх, зөвлөмж, дүгнэлт гаргах, яамны удирдлагыг бодит мэдээллээр хангах, цаашид төлөвлөсөн зорилтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

## Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй.

Хяналтад авсан зорилт, арга хэмжээнүүдийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ыг удирдлага болгов.

Хяналт-шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд яамны эрхлэх асуудлаар тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн 2022 оны эхний хагас жилийн тайлан, бодлогын газруудаас гаргасан үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтэд үндэслэн гүйцэтгэв.

## Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн.

Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар тусгагдсан нийт 17 зорилтын 69 арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Үнэлгээг 2022 оны эхний хагас жилийн байдлаар Засгийн газрын хэрэг эрхлэх газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгдсэн /unelgee.gov.mn/ цахим системд байршуулсан 17 зорилтын 69 арга хэмжээний хүрээнд хийлээ.

Хяналтад авагдсан 69 арга хэмжээний 32 арга хэмжээг яам толгойлон, 37 арга хэмжээг хамтран хэрэгжүүлэхээр тусгагдсан ба нийт 69 арга хэмжээний биелэлт **60.58** %-тай дүгнэгдэв.

Арга хэмжээнүүдийн биелэлтийг бодлогын зорилтоор нь авч үзвэл:

- Ковид-19 халдварт цар тахлаас үүдэлтэй нийгэм эдийн засгийн хүндрэлийг даван туулах бодлогын хүрээний 1 зорилтын 1 арга хэмжээний биелэлт 100.0 хувь,
- Эдийн засгийн бодлогын хүрээний 11 зорилтын 63 арга хэмжээний биелэлт 57.3 хувь,
- Засаглалын бодлогын хүрээний 3 зорилтын 3 арга хэмжээний биелэлт 100.0 хувь,

- Ногоон хөгжлийн бодлогын 2 зорилтын 1 арга хэмжээний биелэлт 100.0 хувь, 1 арга хэмжээний биелэлт 70.0 хувьтай, хэрэгжүүлсэн нийт **69** арга хэмжээний биелэлтийг **60.58** хувьтай дүгнэлээ.

ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ҮНЭЛГЭЭНИЙ ТОВЧОО
/2022 оны эхний хагас жилийн байдлаар/

| **Зорилт** | **Зорилтын тоо** | **Арга хэмжээний тоо** | **Хэрэгжилтийн хувь, арга хэмжээний тоо** | | | | | | **Хэрэгжилт /хувь/** |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 100 | 90 | 70 | 50 | 30 | Төлөвлөгдөөгүй | |
| Нэг.Ковид-19 халдварт цар тахлаас үүдэлтэй нийгэм эдийн засгийн хүндрэлийг даван туулах бодлого | 1 | 1 | 1 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 100.0 |
| Хоёр. Эдийн засгийн бодлого | 11 | 63 | 7 | 12 | 9 | 9 | 25 | 1 | 57.3 |
| Дөрөв. Засаглалын бодлого | 3 | 3 | 3 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 100.0 |
| Тав. Ногоон хөгжлийн бодлого | 2 | 2 | 1 | 0 | 1 | 0 | 0 | 0 | 85.0 |
| **Дүн** | **17** | **69** | **12** | **12** | **10** | **9** | **25** | **1** | **60.58** |

**2022 оны эхний хагас жилийн байдлаар хэрэгжилт байхгүй 0 хувийн биелэлттэй 1 арга хэмжээ байна. Үүнд:**

1. Дорноговь аймагт хар төмөрлөгийн цогцолбор үйлдвэр байгуулна арга хэмжээг гангийн үйлдвэрийн барилгын ажил, тоног төхөөрөмж татан авалт, угсралтын ажлыг гүйцэтгэж, түүхий эдийг татан авч нөөцлөх ажил 88%-тай байхаар төлөвлөсөн боловч хэрэгжилт 0 хувьтай байна.

**2022 оны эхний хагас жилийн байдлаар зорилтот түвшиндээ хүрээгүй 30 хувийн биелэлттэй 25 арга хэмжээ байна.**

**Дөрөв. Дүгнэлт**.

1. Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний гүйцэтгэл 2022 оны эхний хагас жилийн байдлаар **60.58** хувьтай дүгнэснээс 12 арга хэмжээ зорилтот түвшиндээ бүрэн хүрч 100 хувийн гүйцэтгэлтэй, 12 арга хэмжээ гол үр дүн гарч эхэлж байгаа буюу 90 хувь, 10 арга хэмжээ гүйцэтгэл нь тодорхой хэмжээгээр гарч эхэлж байгаа буюу 70 хувь, 9 арга хэмжээ ажил тодорхой хэмжээнд эхэлсэн буюу 50 хувь, 25 арга хэмжээ боловсруулалтын шатанд буюу 30 хувь, 1 арга хэмжээ 0 хувийн хэрэгжилттэй байна.
2. Эрдэнэт үйлдвэрт мөчлөгт урсгалт тээврийн технологи нэвтрүүлэх, Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэр байгуулах, "Багануур" ХК-ийн ил уурхайн үндсэн тоног төхөөрөмжийн шинэчлэл, Асгатын мөнгөний ордын туршилт судалгааны хөрөнгө оруулалтын ажил, арга хэмжээ 2021 оны жилийн эцсийн байдлаар хэрэгжих хугацаа дууссан тул хасагдаж 1:25000-ны масштабын

нарийвчилсан геологийн зураглалын ажлыг эхлэх, нутаг дэвсгэрийн 0.15 хувийг хамруулах ажил шинээр нэмэгдсэн байна.

3. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн "Хэрэгжилтийг хангах, үр дүнг сайжруулах тухай" 03 дугаартай албан даалгавар гарсан боловч хэрэгжилт удааширсан, хангалтгүй хэрэгжилттэй ажлууд нэмэгдсэн тул цаашид авах арга хэмжээнд онцгой анхаарч ажиллах шаардлагатай байна.

**Тав. Санал, зөвлөмж.**

1. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн "Хэрэгжилтийг хангах, үр дүнг сайжруулах тухай" 03 дугаартай албан даалгаварын хэрэгжилтийг хангаж ажиллах.
2. Төрийн байгууллагуудын хамтран хэрэгжүүлэгчээр тусгагдсан зорилт, арга хэмжээний биелэлтийг толгойлон хэрэгжүүлэх байгууллагаас гаргуулан авах, хэрэгжилт хариуцсан нэгжүүдтэй хамтран ажиллах албан хаагчдыг сонгож үүрэгжүүлэх, байнга мэдээлэл солилцож, үр дүнтэй ажиллах шаардлагатай байна.
3. Хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжтэй яамны хариуцсан нэгжүүд нягт, уялдаа холбоотой ажиллах, хэрэгжилтийг хангуулах талаар тогтмол уулзалт зохион байгуулах, хэрэгжилтийг сар, улирлаар шинэчлэн авч хэвших, шалгуур үзүүлэлтийн дагуу зорилтот түвшиндээ хүрч ажиллахыг байнга шаардаж ажиллах нь зүйтэй байна.
4. Зорилтот түвшиндээ хүрээгүй ажлуудын хэрэгжилтэд онцгой анхаарч хэрэгжүүлэгч байгууллагуудтай хамтран тусгайлсан төлөвлөгөө гарган хэрэгжилтийг эрчимжүүлж ажиллаж

ЗГҮАХ-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтэд 2022 оны эхний хагас жилийн байдлаар хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг хавсаргав.

Хянасан:
ХШҮДАГ-ын дарга Ц.Одхүү

Үнэлгээ хийж дүгнэлт зөвлөмж гаргасан:
ХШҮДАГ-ын ахлах шинжээч Х.Цэнд-Аюуш

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР

# ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНД УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ ЭРХЛЭХ АСУУДЛААР ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ 2022 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН БАЙДЛААР

| № | ЗГҮАХ-т тусгагдсан зорилт | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага | Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг) | Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт Хөрөнгийн хэмжээ эх үүсвэр | | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 2022 оны зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Хүрсэн түвшин, үр дүн | |
| | | | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| НЭГ. КОВИД-19 ХАЛДВАРТ ЦАР ТАХЛААС ҮҮДЭЛТЭЙ НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ БОДЛОГО | | | | | | | | |
| 1 | 1.1.6. Нүүрс, бусад уул, уурхайн бүтээгдэхүүний экспортыг эрчимжүүлэх хүрээнд "Ногоон гарц" түр журмыг хэрэгжүүлнэ. Худалдааны түнш орнуудтай эдийн засгийн хамтын ажиллагааг идэвхжүүлж экспортыг нэмэгдүүлнэ. | 1. Нүүрс, уул, уурхайн бусад бүтээгдэхүүний экспортыг эрчимжүүлэх хүрээнд "Ногоон гарц" түр журмыг хэрэгжүүлнэ. Худалдааны түнш орнуудтай эдийн засгийн хамтын ажиллагааг идэвхжүүлж экспортыг нэмэгдүүлнэ. | 2021 - 2024 | ГХЯ, ЗТХЯ, УУХҮЯ, ЭТТ | - | Худалдааны түнш орнуудтай эдийн засгийн хамтын ажиллагааг идэвхжүүлж экспортыг нэмэгдүүлнэ. Нүүрс тээврийн жолооч нарыг БНХАУ-ын талын тусгаарлалтын бүсэд байршуулж, хонуулах ажлыг зохион байгуулж, нүүрс тээврийн жолооч нарыг дархлаажуулалтын вакцинд хамруулах. | Монгол-Хятадын хилийн бүсийн “Ногоон гарц” түр журмын хэрэгжилтийг эрчимжүүлэх саналыг боловсруулж өнгөрсөн онд Гадаад харилцааны яаманд хүргүүлсэн. Мөн нүүрсний тээврийн жолооч нарыг коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын эсрэг дархлаажуулалт болох вакцинжуулалтад хамруулах ажлыг гүйцэтгэсэн. Уул уурхайн бүтээгдэхүүний экспортын тээврийн жолооч нарыг нэн түрүүнд вакцинд хамруулах шийдвэрийг Эрүүл мэндийн яамнаас гаргуулан Гашуун сухайт боомт, Оюутолгойн тээврийн, Шивээ хүрэн боомтын тээврийн жолооч, тээвэр хариуцсан ажилчдыг Өмнөговь аймгийн Эрүүл мэндийн газрын даргын тушаалаар томилогдсон ажлын хэсэг вакцинд хамруулаад байна. Ногоон гарц хөтөлбөр хэрэгжсэнээр Өмнөговь аймгийг “Ногоон бүс” болгон хамгаалж, ялангуяа Гашуунсухайт боомт, Цагаанхадны гаалийн бүсүүдийг улсын хамгаалалтанд авч вакумжуулж хилээр нэвтрэх тээврийн хэрэгслийн эрүүл ахуй, халдвар хамгаалалтын тал дээр онцгой анхаарч ажилласан. Ингэснээр аливаа эрсдэлээс сэргийлж хилийн нэвтрэн өнгөрүүлэх хүчин чадлыг сайжруулах тал дээр анхаарч ажилласан. 2022.06.02-ны байдлаар 5867.3 мян.тн нүүрс, 622.0 мян.тн зэсийн баяжмал, 1441.8 мян.тн төмрийн хүдэр, баяжмал, 48.9 мян.тн цайрын баяжмал, 113.5 мян.тн хайлуур жоншны баяжмал экспортод тус тус гаргаад байна. Нүүрс 16%, зэсийн баяжмал 51.3%, төмрийн хүдэр, баяжмал 15.2%, цайрын баяжмал 36.5%, хайлуур жоншны баяжмал 12.7%-ийн экспортын гүйцэтгэлтэй байна. | 100 |
| ГУРАВ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО | | | | | | | | |
| 2 | 3.2.1. Стратегийн | 1. Оюутолгойн төслийг Монгол | 2021 - 2024 | “Оюу Толгой” ХХК | Далд уурхайд 2021 оноос | Далд уурхайн бүтээн | УУХҮСайдын 2022.05.19-ний өдрийн А/113 тоот тушаалаар “Оюу толгой” ХХК-ийн далд уурхайн бүтээн байгуулалттай | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | ач холбогдол бүхий ордуудын эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлнэ: | Улсын хууль тогтоомжид нийцүүлж, далд уурхайг ашиглалтад оруулна. | | | 2022 оны 6-р сар хүртэл 800.5 сая ам.доллар зарцуулсан. 2022 онд 1257.3 сая ам.доллар зарцуулахаар төлөвлөсөн. | байгуулалт 73 хувьд хүргэнэ. Далд уурхайг ашиглалтад хүлээн авна. | газар дээр нь үзэж танилцаж, далд уурхайг ашиглалтад хүлээн авах эсэх асуудлаар санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий Комиссын бүрэлдэхүүнийг баталсан. Дээрх тушаалын дагуу УУХҮЯ, ЭХЯ, БОАЖЯ, МХЕГ, АМГТГ, ОБЕГ, Өмнөговь аймгийн засаг даргын тамгын газар, “Оюу толгой” ХХК, “Эрдэнэс оюу толгой” ХХК-ийн төлөөлөл оролцсон комисс 2022.05.25-ны өдөр Оюу толгойн далд уурхайд ажиллаж, далд уурхайн бүтээн байгуулалт гүйцэтгэлтэй танилцаж, далд уурхайг хүлээж авах хүртэл, хугацаатай үүрэг даалгавар, зөвлөмж өгч ажилласан. Оюу толгой төслийн далд уурхай ашиглалтад орсноор жилд 40.0 сая тн хүдэр олборлож, 1,553.0 мян.тн зэсийн баяжмал үйлдвэрлэнэ. Зэсийн баяжмал дахь зэс 436.0 мян.тн, алт 502.0 мян.унц, мөнгө 3495.0 мян.унцад хүрнэ. Оюу толгой төслийн далд уурхай ашиглалтад орсноор зэсийн баяжмал үйлдвэрлэл 622 мян.тн-оос 1553 мян.тн болж 2.4 дахин өссөнөөр Монгол Улсын экспортын орлого 26.62 хувиар нэмэгдэнэ. 2022 оны хагас жилийн байдлаар Оюу толгойн далд уурхайн төслийн барилгын ажлын гүйцэтгэл-90%, материал зөөвөрлөх системийн гүйцэтгэл-90%, далд уурхайн бүтээн байгуулалт 83.7%-д хүрсэн. | |
| 3 | | 2. "Эрдэнэт үйлдвэр" төрийн өмчит үйлдвэрийн газрын өмчлөлтэй холбоотой асуудлыг эцэслэн шийдвэрлэж, ил уурхай, баяжуулах үйлдвэр, засвар механикийн заводод өргөтгөл, шинэчлэлийг хийж, үйлдвэрлэлийн хүчин чадал, өгөөжийг нэмэгдүүлнэ. | 2020 - 2024 | "Эрдэнэт Үйлдвэр" ТӨҮГ, ТӨБЗГ | 322,939.3 сая.төг Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт /Өөрийн хөрөнгөөр 13.1 %- ийг, зээлээр 86.9%- ийг (“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ) | Хүдрийн ил уурхайд мөчлөгт урсгалт тээврийн технологи нэвтрүүлэлт 100 хувьд, Баяжуулах үйлдвэрийн өргөтгөл, шинэчлэл шинэчлэл 64 хувьд, засварын механикийн заводын өргөтгөл, шинэчлэл 51 хувьд хүргэнэ. | Хүдрийн ил уурхайд мөчлөгт урсгалт тээврийн технологи нэвтрүүлэлт 80%-д хүрсэн. Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэрийн бүтээн байгуулалт 93%-тай. Баяжуулах үйлдвэрийн өргөтгөл, шинэчлэл 90%-д хүрсэн. Засварын механикийн заводын ТЭЗҮ боловсруулах ажил 40%-д хүрсэн. "Эрдэнэт Үйлдвэр" ТӨҮГ-ын ил уурхай, баяжуулах үйлдвэр, засвар механикийн заводод өргөтгөл, шинэчлэлийг хийж, үйлдвэрлэлийн хүчин чадал, өгөөжийг нэмэгдүүлэх ажлын гүйцэтгэл 75%-тай байна. | 90 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 4 | | 2.3. Баяжуулах үйлдвэрийн өргөтгөл, шинэчлэл | 2020 - 2023 | "Эрдэнэт Үйлдвэр" ТӨҮГ, туслан гүйцэтгэгч "Jiangxi Naipu mining machinery and new materials" Co.ltd, "FLSmidth Mongolia" ХХК | 558,528.0 сая.төг Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт /Өөрийн хөрөнгөөр 36%-ийг, зээлээр 64%-ийг ("Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ) | Баяжуулах үйлдвэрийн өргөтгөл, шинэчлэл 73 хувьд хүрнэ. Жилийн хүдэр боловсруулах хүчин чадал 35 сая тонн хүртэл өсгөнө. | Баяжуулах үйлдвэрийн өргөтгөл, шинэчлэлд 2022 оны хагас жилийн байдлаар 339,899.8 сая төгрөг зарцуулсан. Баяжуулах үйлдвэрийн өргөтгөл, шинэчлэлийн тендерт Jiangxi Naipu mining machinery and new materials Co.ltd компани гүйцэтгэгчээр шалгарсан. "Erdenet light", "Эрчим төсөл" компаниуд туслан гүйцэтгэгчээр ажиллаж байна. Тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл 99%-тай. Тоног төхөөрөмжүүдийн нийлүүлэлт хийгдэж байна. БНХАУ-аас эхний ээлжинд ирэх мэргэжилтнүүдийн МУ-д нэвтрэх визний зөвшөөрөл гарсан. Мөн хүдрийн агуулах угсрах 61 ажилтны виз гарсан. Төлөвлөгөөний дагуу газар шорооны ажил хийгдэж, үндсэн тоног төхөөрөмжийн суурийг цутгаж байна. Газар шорооны ажил 95%. Бетон цутгалт 93%. Төмөр хийц нийлүүлэлт 100%. Тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл 100%-ийн гүйцэтгэлтэй байна. Нийт төслийн гүйцэтгэл-90%. | 100 |
| 5 | | 2.4. Засварын механикийн заводын өргөтгөл, шинэчлэл | 2020 - 2024 | "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ | 28,452.8 Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт /Өөрийн хөрөнгөөр 22%-ийг, зээлээр 78%- ийг ("Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ) | Засвар, механикийн заводын өргөтгөл, шинэчлэлийг 70%-д хүргэнэ. | "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ нь Засвар, механикийн заводыг (2020-2024 он) үндэсний машин үйлдвэрийн суурь болгон хөгжүүлэх өргөтгөл, шинэчлэлийн нарийвчилсан техник-эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж "Ди Ди Эй Жи" ХХК-тай 2021.08.24-ний өдрийн 5/196-21 тоот гэрээ байгуулсан. Нарийвчилсан ТЭЗҮ-г эцсийн байдлаар боловсруулж дууссан ба "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-аас ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлэхээр "Шинжээч томилуулах тухай" 2022.05.23-ны өдрийн ТБ-105-12/2446 дугаар албан бичиг ирүүлсэн. УУХҮСайдын тушаалаар шинжээчдийн баг томилохоор ажиллаж байна. | 30 |
| 6 | | 3. Цагаан суваргын зэс, молибденийн ордыг ашиглалтад оруулна. | 2021 - 2024 | "Эрдэнэ цагаан суварга" ХХК | 796,678.0 сая төгрөг. | Бүтээн Бүтээн байгуулалтын ажил 93 хувьтай. Уулын баяжуулах үйлдвэрийн тоног төхөреөмжийн угсралт хийж дуусах, туршилт, тохируулгын ажлыг хийх, баяжуулах үйлдвэрийг ашиглалтад оруулна. | Цагаан суваргын зэс, молибденийн ордыг ашиглах ТЭЗҮ-ийн тодотголыг боловсруулж өнгөрсөн онд Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн. Өнөөдрийн байдлаар бүтээн байгуулалтын ажил 69%-тай. Уулын баяжуулах үйлдвэрийн тоног төхөөрөмжийн угсралт, туршилт, тохируулгын ажлыг 2023 онд хийж баяжуулах үйлдвэрийг ашиглалтад оруулахаар төлөвлөж байна. Төслийн талбайд 2022 онд барилга угсралтын ажил хийгдээгүй. Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны 1 дүгээр албан даалгаварт тусгагдсан Цагаан суваргын зэс, молибдений төслийг эрчимжүүлэх арга хэмжээний талаар танилцуулга бэлтгэн Засгийн газрын 2022.04.20-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж холбогдох шийдвэрийг гаргуулсан. Монгол Улсын Засгийн газрын 2022.04.20-ны өдрийн 24 дүгээр тэмдэглэлийн 1-д Цагаан суваргын зэс, молибдений ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах хүрээнд тоног төхөөрөмж суурилуулалт, барилгын бүтээн байгуулалтын ажилд шаардлагатай гадаадаас ажиллах хүч, мэргэжилтнийг авах талаар холбогдох хууль тогтоомжид | 50 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | нийцүүлэн арга хэмжээ авч ажиллахыг УУХҮЯ, ХНХ-ийн сайд нарт даалгасан. УУХҮСайд тус төслийн бүтээн байгуулалтай газар дээр нь очиж танилцсан. | |
| 7 | | 4. Багануур, Шивээ-Овоогийн нүүрсний уурхайд өргөтгөл хийж, олборлолтын хүчин чадлыг нэмэгдүүлж өртөг, зардлыг бууруулна. | 2020 - 2024 | "Эрдэнэс Монгол" ХХК "Багануур" ХК, "Шивээ-Овоо" ХК | | "Багануур" ХК-ийн ил уурхайн үндсэн тоног төхөөрөмжийн шинэчлэлт 100%, Шивээ-Овоогийн нүүрсний уурхайн үндсэн тоног төхөөрөмжийн шинэчлэлт 36%-д хүргэнэ. | Багануурын нүүрсний уурхай үндсэн тоног төхөөрөмжийн шинэчлэлт 50%, Шивээ-Овоогийн нүүрсний уурхайн үндсэн тоног төхөөрөмжийн шинэчлэлт 35%-д хүрсэн. | 70 |
| 8 | | 4.2. Шивээ-овоогийн нүүрсний уурхайн өргөтгөлийн үлдэгдэл хөрөнгө оруулалт. | 2020 - 2024 | "Эрдэнэс Монгол" ХХК "Шивээ-Овоо" ХК | 6794.1 сая.төг /Зээлийн шимтгэл, даатгал орсон дүнгээр/ | Үндсэн тоног төхөөрөмжийн шинэчлэлт 68%-д хүргэнэ. | 2020 оноос хэрэгжүүлж эхэлсэн JBIC төслийн гүйцэтгэл 100 хувийн биелэлттэй байна. Төслийн хүрээнд 5 технологийн автомашин 60 тонны Komatsu HD465 мөн 2 PC1250 гидро экскаватор нийлүүлэгдэж 14787.7 сая төгрөгийн төсөл хэрэгжүүлж техник тоног төхөөрөмжийн шинэчлэл хийгдсэн. 2022 оны эхний хагас жилийн байдлаар JBIC төслийн санхүүжилтийн хэрэгжилт 37.6 хувийн биелэлттэй буюу 5.6 тэрбум төгрөг төлөөд байна. Шивээ Овоогийн уурхайг түшиглэн барих 200 мВт-ын цахилгаан станцтай холбоотойгоор конвейерийн систем, төмөр замын дотоод тээврийн төсөл бүхэлдээ шийдвэрлэгдэнэ. | 90 |
| 9 | | 5. Асгатын мөнгөний ордыг эдийн засгийн эргэлтэд оруулахад шаардлагатай туршилт, судалгаа хийж, хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэнэ. | 2020 - 2024 | "Эрдэнэс Монгол" ХХК | | Асгатын мөнгөний ордыг эдийн засгийн эргэлтэд оруулахад шаардлагатай туршилт, судалгаа хийж, хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэх ажил 20%-д хүргэнэ. | 2022 оны хагас жилийн байдлаар Асгатын мөнгөний ордыг эдийн засгийн эргэлтэд оруулахад шаардлагатай туршилт, судалгаа хийж, хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэх ажил 7%-д хүрсэн. БНХАУ-н Гашуун сухайт, Ганц модны боомтын хил нэвтрүүлэлт эрс буурсантай холбоотой компанийн санхүүгийн хүндрэлтэй нөхцөл байдал үүссэн тул тус ажил нь тодорхойгүй хугацаагаар хойшлогдоод байна. | 30 |
| 10 | | 5.2. Асгатын мөнгөний ордын зөвлөх | 2020 - 2022 | "Эрдэнэс Монгол" ХХК | 500.0 сая төгрөг | Зөвлөх үйлчилгээний хөрөнгө | "Эрдэнэс Монгол" ХХК-ийн саналыг үндэслэн тус яамнаас 2021 онд Барилга хот байгуулалтын сайдын 2022 оны төсвийн төслийн ТЭЗҮ, зураг, төсвийн жагсаалтад Асгатын | 30 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | үйлчилгээний хөрөнгө оруулалт. | | | | оруулалт 100% хувьд хүргэх. | мөнгөний ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах хүрээнд шаардлагатай туршилт, судалгааны ажлыг тусгуулахаар санал хүргүүлсэн. 2022 оны төсвийн төсөлд 1.0 тэрбум төгрөгийг төсөвлөн холбогдох саналыг Сангийн яаманд хүргүүлж Барилга хот байгуулалтын яамны төсөвт тусгуулсан. УУХҮЯ-наас "Асгатын мөнгөний ордыг эдийн засгийн эргэлтэд оруулахад шаардагдах ТЭЗҮ, судалгаа" төсөл, арга хэмжээнд батлагдсан хөрөнгийг тус ордод нарийвчилсан хайгуулын ажил хийж, нөөцийг тодотгох арга хэмжээний зардалд шилжүүлэх тухай хүсэлтийг БХБЯ-нд хүргүүлсэн. БХБСайдын 2022.03.03-ны өдрийн 1/856 дугаар албан бичигт Улсын Их Хурлын Байнгын хорооны 2022 оны "Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай" 01 дүгээр тогтоолын 3-т Асгатын мөнгөний ордод нарийвчилсан хайгуулын ажил гүйцэтгэх, техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлын хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэхийг "Эрдэнэс Монгол" ХХК-д хариуцуулсан заалт болон холбогдох хуультай нийцэхгүй байх тул шийдвэрлэх боломжгүй гэсэн хариу ирүүлсэн. | - |
| 11 | | 5.3. Асгатын мөнгөний ордын нэмэлт хайгуулын ажлын хөрөнгө оруулалт. | 2021 - 2024 | "Эрдэнэс Монгол" ХХК | 1000.0 /Төрийн өмчит компанийн санхүүжилтээр/ | Нэмэлт хайгуулын ажлын гүйцэтгэл 33 хувьд хүргэнэ. | Засгийн газрын 2022.03.16-ны өдрийн хуралдааны 16 дугаар тэмдэглэлд ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэх саналаа танилцуулахыг "Эрдэнэс Монгол" ХХК (О.Хулан)-д даалгасан. УУХҮСайдын 2022.03.31-ний өдрийн 01/801 дугаар албан бичгээр ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах ажлын нарийвчилсан төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэх саналаа яаралтай танилцуулахыг үүрэг болгосон. "Эрдэнэс Монгол" ХХК-иас ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэх нарийвчилсан төлөвлөгөө ирүүлээгүй байна. | 30 |
| 12 | | 6.Тавантолгойн нүүрсний бүлэг ордын дэд бүтцийг бүрдүүлж, үйлдвэрлэл, технологийн парк байгуулах ажлын хүрээнд нүүрс баяжуулах үйлдвэрийг ашиглалтад оруулна. | 2021 - 2024 | "Эрдэнэс-Тавантолгой" ХК | 640,188.0 /Төрийн өмчит компанийн санхүүжилтээр/ | Тавантолгойн нүүрсний бүлэг ордын дэд бүтцийг бүрдүүлж, үйлдвэрлэл, технологийн парк байгуулах ажлын хүрээнд нүүрс баяжуулах үйлдвэрийг ашиглалтад оруулах ажил | Нүүрс баяжуулах үйлдвэрийн ерөнхий гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, төслийн талбайд инженер геодизийн судалгаа, түгээмэл тархацтай ордын судалгааны ажлуудыг эхлүүлсэн бөгөөд төслийн гүйцэтгэл 12%-тай байна. Нүүрс, хөрс тээврийн техник, тоног төхөөрөмжийн нэвтрүүлэлт 7 хувьд хүрсэн. Ачилтын нэгдсэн төвийн бүтээн байгуулалтын ажил 2022 оны 4 сард эхэлсэн бөгөөд ажлын гүйцэтгэл 21%-тай байна. Загийн усны хоолой усан хангамжийн төслийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлсэн бөгөөд төслийн нийт гүйцэтгэл 26%-д хүрсэн. | 70 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 40 хувьд хүргэнэ. | | |
| 13 | | 6.1. 3.2.1.6.1. Техник, тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт. | 2020 - 2024 | "Эрдэнэс-Тавантолгой" ХК | 61,742.0 /Төрийн өмчит компанийн санхүүжилтээр/ | Нүүрс, хөрс тээврийн техник, тоног төхөөрөмжийн нэвтрүүлэлт 11%-д хүргэнэ. | 2022 оны 5-р сарын байдлаар уурхайд 86 тэрбум төгрөг бүхий 23 ш техник, тоног төхөөрөмжийг худалдан авч нүүрс, хөрс тээврийн техник, тоног төхөөрөмжийн нэвтрүүлэлт 7%-д хүрсэн. 130 тн даацтай автосамосвал 12 ш, 12 м$^3$ утгуурын багтаамжтай экскаватор 2ш, 7-8 м$^3$ утгуурын багтаамжтай экскаватор 2 ш, 13.7 м$^3$ хутганы багтаамжтай бульдозер 1 ш, 10 м$^3$ хутганы багтаамжтай дугуйт түрэгч 1ш, 8.5 м$^3$ хутганы багтаамжтай бульдозер 1 ш, 4.3 м$^3$ хутганы урттай автогрейдер 1 ш, тус бүр 20 м$^3$ ёмкостой усны болон түлшний автоцистерн зэрэг техник тоног төхөөрөмжүүдийг худалдан аваад байна. Гэрээний дагуу техник тоног төхөөрөмжийн нийлүүлэлт хийгдэж байгаа бөгөөд нийлүүлэлт хийгдсэн техникүүд уурхайд ажиллаж байна. Компанийн А6-20 дунд хугацааны бизнес төлөвлөгөөний дагуу уулын үндсэн болон туслах техникүүд худалдан авах тендерийн ажил үргэлжилж байна. Нүүрс, хөрс тээврийн техник, тоног төхөөрөмжийн нэвтрүүлэлт 7 хувьд хүрсэн. | 90 |
| 14 | | 6.2. 3.2.1.6.2. Конвейерийн системийн хөрөнгө оруулалт. | 2021 - 2024 | "Эрдэнэс-Тавантолгой" ХК | 99,300.0 /Төрийн өмчит компанийн санхүүжилтээр/ | Цанхийн баруун уурхайн хөрсний конвейерийн систем нэвтрүүлэлт 22 хувьд хүргэнэ. | Конвейерын системийн ТЭЗҮ боловсруулах, зөвлөх үйлчилгээг “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн инженерүүд, гадаадын болон үндэсний зөвлөх, инженерүүдтэй хамтран гүйцэтгэхээр 2022 оны төсөвт суулгаж ТУЗ-д танилцуулж батлуулсан. “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн нэр дээр ТЭЗҮ боловсруулах тусгай зөвшөөрөл авах ажлыг амжилттай зохион байгуулж улмаар Гүйцэтгэх захирлын 2022 оны А/87 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулагдан конвейерын системийн ТЭЗҮ боловсруулах ажил хийгдэж байна. | 30 |
| 15 | | 6.3. 3.2.1.6.3. Нүүрс баяжуулах үйлдвэр | 2021 - 2023 | "Эрдэнэс-Тавантолгой" ХК | 355,660.0 сая.төг | Нүүрс баяжуулах үйлдвэрийн 1-р модулын бүтээн байгуулалтын ажил 81%-д хүргэнэ. | 2021.08.13-ны өдөр Нүүрс баяжуулах үйлдвэрийн барилгын зураг төсөв боловсруулах, барилга угсралтын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах 956.4 тэрбум төгрөгийн өртөг бүхий тендерийг зарласан бөгөөд тус тендер 2 удаа амжилтгүй болж улмаар 2022.02.17-ны өдөр дахин тендерийг зарлаж, 2022.03.02-ны өдөр нээн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан. Төслийн гүйцэтгэгчээр шалгарсан "Норинко Интернэшнл" ХХК-тай 2022.04.14-ний өдөр гэрээ байгуулан ажлыг эхлүүлсэн. 2022.05.25-ны өдрийн байдлаар төслийн талбайд түр оффис, талбайн инженер геодизийн судалгаа, түгээмэл тархацтай ордын судалгааны ажлууд хийгдэж байна. Баяжуулах үйлдвэрийн 1-р модулын бүтээн байгуулалтын ажил 12%-д хүрсэн. | 50 |
| 16 | | 6.4. 3.2.1.6.4. Ачилтын нэгдсэн төв байгуулах. | 2021 - 2022 | "Эрдэнэс-Тавантолгой" ХК | 38,126.0 /Төрийн өмчит компанийн санхүүжилтээр/ | Ачилтын нэгдсэн төв байгуулах | ТНАЛТ-ийн үндсэн тоног төхөөрөмжүүдийн худалдан авалтын захиалга хийгдсэн бөгөөд төслийн бүтээн байгуулалтын ажил 2022.04.22-ны өдөр эхэлсэн. Төслийн гүйцэтгэл 2022.05.17-ны өдрийн байдлаар 21%-тай байна. | 50 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ажил 100%-д хүргэнэ. | ТНАЛТ-ийн вагонд ачигчийн суурийн ухлагын ажил дуусч, инженерийн зураг төслийн ажлууд хийгдэж байна. | |
| 17 | | 6.5. 3.2.1.6.5. Усан хангамж шийдвэрлэх. | 2021 - 2023 | "Эрдэнэс-Тавантолгой" ХК | 71,931.4 /Төрийн өмчит компанийн санхүүжилтээр/ | Усан хангамжийн ажил 20%-д хүргэнэ. | Тавантолгойн нүүрсний бүлэг ордыг түшиглэн байгуулах төслүүдийн усны хэрэгцээг эхний ээлжинд "Загийн усны хоолой"-н газрын доорх усны ордоос, дараагийн үе шатанд гадаргын усны төсөл хэрэгжих хүртэлх хугацаанд Дорноговь аймгийн Мандах сумын нутагт байрлах "Цагаан цав" газрын доорх усны ордоос хангахаар төлөвлөн ажиллаж байгаа бөгөөд Загийн усны хоолойн газрын доорх усны ордоос шугам хоолой татах төслийн гүйцэтгэл 2022.06.15-ны өдрийн байдлаар 30 орчим хувьтай явж байна. Мөн Тавантолгойн нүүрсний бүлэг ордуудыг түшиглэн баригдах төслүүдийн ус хангамжийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх тухай албан хүсэлтийг холбогдох судалгаа мэдээллийн хамт БОАЖЯ-нд 2022.04.26-ны өдрийн 01/1186 дугаар албан бичгээр хүргүүлсэн бөгөөд Усны газрын 2022.05.18-ны өдрийн 01/581 дугаар албан бичгээр Тавантолгойн дулааны цахилгаан станц болон Нүүрс баяжуулах үйлдвэр төслүүдийн ус хангамжийн эх үүсвэрийг Дорноговь аймгийн Мандах сумын Цагаан цавын газрын доорх усны ордоос хангах боломжтойг мэдэгдэж, төслийн дараагийн шатанд шаардлагатай ус хангамжийн эх үүсвэрийг тодорхойлох асуудлыг шийдвэрлэсэн. | 50 |
| 18 | 3.2.2. Томоохон ордуудыг ашиглалтад оруулж, экспортын хэмжээг нэмэгдүүлнэ: | 1. Салхитын мөнгөний ордыг төслийн хүчин чадалд хүргэж ашиглана. | 2021 - 2024 | "Эрдэнэс силвер ресурс" ХХК | | Салхитын мөнгөний ордыг төслийн хүчин чадалд хүргэнэ. | Салхит уулын Баяжуулах 1 дүгээр үйлдвэр жилд 300 мян.тн хүдэр боловсруулах хүчин чадалтай бөгөөд 2022 оны 05 дугаар сарын байдлаар 1,194.9 тонн баяжмал боловсруулан тасралтгүй ажиллаж байна. Дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахлын нөлөөгөөр бараа материал, тоног төхөөрөмжийн хомстол үүсч, татан авалт удааширсны улмаас Баяжуулах 2 дугаар үйлдвэр төлөвлөгөөт хугацаанд ашиглалтад оролгүй хойшилсон. 2022 оны 07 дугаар сард ашиглалтад орох төлөвлөгөөтэй ажиллаж байна. | 90 |
| 19 | | 2. Зүүн цагаан дэлийн жоншны далд уурхайг ашиглалтад оруулна. | 2021 - 2024 | Монголросцветмет ТӨҮГ | 39.5 тэрбум төгрөг. | Зүүн цагаан дэлийн жоншны далд уурхайг ашиглалтад оруулна. 100 хувьд хүргэнэ. | Зүүн Цагаан дэлийн жоншны далд уурхайг ашиглах ТЭЗҮ, БОННҮ, Уулын ажлын төлөвлөгөө, Байгал орчны менежментийн төлөвлөгөө зэрэг баримт бичгүүдийг батлуулсан. Цахилгаан дамжуулах 6000 кВт-ын 3.5 км түр агаарын шугамыг барьсан. 2022 оны хагас жилийн байдлаар налуу ам болон бусад малталтуудын хэмжээнд 485 м нэвтэрч 4673 $м^3$ уулын цулын ажил гүйцэтгээд байна. Уурхайн ажилчдын байрыг засаж ашиглалтад оруулсан. Зүүн цагаан дэлийн жоншны далд уурхайг ашиглалтад оруулах бэлтгэл ажил 40 хувьд хүрсэн. Төлөвлөсөн ажлын гүйцэтгэл 100%. | 90 |
| 20 | 3.2.3. Улсын төсвийн хөрөнгөөр | 1. 1:50000-ны масштабын геологийн | 2021 - 2024 | УУХҮЯ | Улсын төсөв Батлагдсан: 10,587.4 | Нутаг дэвсгэрийн 45%-ийг | Сүүжийн говь-50, Шүтээн улаан уул-50, Норовлин-50, Чулуун хороот-50 төслүүдийн үр дүнгийн тайлантай танилцаж Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн салбар зөвлөлийн | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хийгдэх геологи, судалгааны ажлыг эрчимжүүлж, эрдэс баялгийн нөөцийг нэмэгдүүлнэ. | зураглал, ерөнхий эрлийн ажлын хэмжээг нэмэгдүүлж, нутаг дэвсгэрийн 47%-ийг хамруулна | | | Гүйцэтгэл: 1,545.2 Санхүүжилт: 683.3 | хамруулах, ашигт малтмалын хэтийн төлөвтэй 18 талбай ялгана | хуралдаанаар 2022.06.02-нд хэлэлцэж хүлээн авсан. Ингэснээр 17,787.84 км$^2$ талбай буюу 1.13%, нийтдээ 43.1%-ийг тус судалгааны ажилд хамруулаад байна. Эдгээр 4 төслийн судалгааны үр дүнд алтны шороон илрэл Хуурай сайр (P2 зэргээр 224.19 кг), Угалзын худаг (P2 зэргээр 1524.1 кг), Дөшийн ам (P3 зэргээр 80 кг), Баян тохой, Цагаан толгой, Их Номгон, зэсийн Урт булаг, Ил худаг, холимог металлын Буйлст, элсний Угалзын ам, шаврын Зуух булаг (P1 зэргээр 232.8 мян.тн), Ширээ тээг (P1 зэргээр 26.1 сая тн) зэрэг ашигт малтмалын хэтийн төлөвтэй талбайг ялгасан..<br>2022 онд 33 төслийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Үүнд:<br>1. Үргэлжлэн хэрэгжих болон шинээр эхлэх нийт 33 төслийн 2022 оны төсөв, төлөвлөгөөг УУХҮСайдын 2022 оны А/29 дүгээр тушаалаар батлуулсан.<br>2. Үргэлжлэн хэрэгжих 27 төслийн 2022 оны хээрийн болон суурин боловсруулалтын ажлын хэмжээ, арга, аргачлалттай танилцан хянаж ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлсэн. ЭБМЗ-ийн төсөл тус бүрийн дүгнэлтийг үндэслэн УУХҮСайдын 2022 оны тушаалаар баталгаажуулан ажиллаж байна.<br>3. Шинээр хэрэгжүүлэх Баянзүрх уул-50, Ханхар уул-50, Үүрэг нуур-50, Мөст уул-50, Ямбат уул-50, Овоот шар-50 нийт 6 төслийн геологийн даалгаврыг боловсруулан 2022.01.20-ны өдөр УУХҮ-ийн Дэд сайдаар батлуулсан.<br>4. Төслүүдийн гүйцэтгэгчийг шалгаруулах тендерийг Үндэсний геологийн алба нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн дагуу УУХҮСайдаас эрх шилжүүлсэнтэй холбоотойгоор гүйцэтгэж байна. Төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах зөвлөх үйлчилгээний тендерийг 2022.02.25-ны өдөр www.tender.gov.mn цахим системээр зарласан бөгөөд 2022.04.06-ны өдөр тендерийн урилгыг хураангуй жагсаалтад орсон оролцогчидод хүргүүлж 2022.05.06-ны өдөр тендерийг нээсэн. Хамгийн сайн оролцогчоор шалгарсан хуулийн этгээдтэй зөвлөх үйлчилгээний гэрээг байгуулж ажлыг эхлүүлээд байна. | |
| 21 | | 2. 1:25000-ны масштабын нарийвчилсан геологийн зураглалын ажлыг эхлэх, нутаг дэвсгэрийн | 2022 - 2024 | УУХҮЯ | Улсын төсөв 2,000.0 | Нутаг дэвсгэрийн 0.05%-д судалгааны ажлыг эхлэнэ. | Төрийн нарийн бичгийн даргын 2022.03.07-ны өдрийн 03/577 дугаартай албан бичгээр 1:25000-ны масштабын нарийвчилсан геологийн зураглал гүйцэтгэх, түүнд тавигдах шаардлагын төслийг боловсруулан 2022 оны II улиралд багтаан ирүүлэх тухай албан бичгийг ҮГА-нд хүргүүлсэн. Мөн Гадаадын зээл тусламжаар хэрэгжүүлж байгаа Австрали-Монголын эрдэс баялгийн салбарын хамтын ажиллагааны хөтөлбөрийн 2022-2023 оны санхүүгийн жилийн үйл | 30 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 0.15 хувийг хамруулна | | | | | ажиллагааны төлөвлөгөөнд тус зааврыг боловсруулах саналыг хүргүүлсэн.<br>ҮГА шаардлагын төсөл боловсруулах ажлын хэсэг байгуулан ажиллаж байна. | |
| 22 | | 3. Улсын геологийн 1:200000-ны масштабын иж бүрдэл зургийг нэгтгэж дуусах, нутаг дэвсгэрийн 100 хувь хамруулна | 2021 - 2023 | УУХҮЯ | Улсын төсөв Батлагдсан: 1,269.2 Гүйцэтгэл: 330.1 Санхүүжилт: 119.3 | L, M /N/ хавтгай буюу нутаг дэвсгэрийн 60%-ийг хамруулна. | Монгол орны нутаг дэвсгэрийн 14.1%-ийг хамарсан К хавтгайн хэмжээнд Улсын геологийн 1:200000-ны масштабын иж бүрдэл зургийг нэгтгэх УГЗ-200-К-нэгтгэл төслийн үр дүнгийн тайлантай танилцан ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлэн УУХҮСайдын 2022 оны А/03 дугаар тушаалаар хүлээн авсан. Ингэснээр нутаг дэвсгэрийн 14.1%-ийг 1:200000-ны масштабын иж бүрдэл зургийн нэгтгэлд хамруулсан бол L хавтгайн хэмжээнд хээрийн судалгааны ажлыг бүрэн дуусгаснаар нутаг дэвсгэрийн 53%-ийг судалгаанд хамруулаад байна. | 90 |
| 23 | | 4. Агаарын геофизикийн 1:200000-ны масштабын соронзон судалгааны ажлыг хэрэгжүүлэх, нутаг дэвсгэрийн 70 хувийг хамруулна | 2021 - 2024 | УУХҮЯ | Улсын төсөв Батлагдсан: 163.7 Гүйцэтгэл: - Санхүүжилт: - | Ховд-2020 төслийг үргэлжлүүлэх, нутаг дэвсгэрийн 66%-ийг судалгааны ажилд хамруулна. | 1. Монгол Улсын баруун, баруун өмнөд хэсгийг хамарсан талбайд 1:200000-ны масштабтай агаарын геофизикийн цогцолбор судалгааны 2022 оны хээрийн шалгах ажлын төсөв, төлөвлөгөөг УУХҮСайдын 2022 оны А/29 дүгээр тушаалаар баталсан.<br>2. Ховд-2020 төслийн 2022 оны хээрийн ажлын хэмжээ, арга, аргачлалыг ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлэн УУХҮСайдын шийдвэрээр баталгаажуулахаар ажиллаж байна.<br>3. 2020-2021 онд нийт 104,044.0 кв.км буюу нутаг дэвсгэрийн 6.6%-д агаарын геофизикийн хэмжилт хийх нислэгийг дуусгасан. Нислэгийн ажлыг дуусгаснаар нутаг дэвсгэрийн 66%-ийг судалгаанд хамруулсан бөгөөд үр дүнгийн тайланг 2023 онд хэлэлцэн хүлээн авна. | 100 |
| 24 | | 5. Геохимийн 1:1000000-ын масштабын зураг зохиох ажлыг хэрэгжүүлэх, нутаг дэвсгэрийг 100 хувь хамруулна | 2021 - 2022 | УУХҮЯ | Улсын төсөв Батлагдсан: 125.5 Гүйцэтгэл: 21.1 Санхүүжилт: 9.4 | Геохими-2019 төслийг үргэлжлүүлэх, нутаг дэвсгэрийн 100%-ийг судалгааны ажилд хамруулна. | 1. 2009-2011 онд МУ, БНХАУ-ын хилийн дагуу 501,909 км$^2$ талбайг буюу 32.1%-ийг 1:1000000-ын масштабын геохимийн судалгааны ажилд хамруулсан бөгөөд 2019 оноос Монгол орны нийт нутаг дэвсгэрийг уг төслийн ажилд 100% хамруулах ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлж эхэлсэн.<br>2019-2021 онд нутаг дэвсгэрийн үлдсэн 1,062,197.0 км$^2$ буюу 67.9%-д хээрийн судалгаагаар хамруулж дууссан.<br>2. 2019-2021 онд гүйцэтгэсэн хээрийн судалгааны ажлын үр дүнд боловсруулсан үр дүнгийн тайлан хамгаалах ажлын төсөв, төлөвлөгөөг УУХҮСайдын 2022 оны А/29 дүгээр тушаалаар батлуулж ажлыг эхэлсэн.<br>3. Төслийн 2022 оны суурин боловсруулалтын ажлын хэмжээ, арга, аргачлалыг ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлэн УУХҮСайдын шийдвэрээр баталгаажуулахаар ажиллаж байна. | 70 |
| 25 | | 6. Бүс нутаг болон | 2021 - 2024 | УУХҮЯ | Улсын төсөв Батлагдсан: | Эрдэнэт хотын | 1.2022 онд үргэлжлэх Эрдэнэт, Дархан, Ховд хотын геоэкологи, гидрогеологийн судалгааны ажлыг | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | хотуудын геоэкологи, гидрогеологи, геотермийн судалгааны ажил хийнэ | | | 2,137.7 Гүйцэтгэл: 278.7 Санхүүжилт: 133.9 | судалгааны үр дүнг хүлээн авах, Дархан, Ховд хотын судалгааг үргэлжлүүлэх, Чойбалсан, Даланзадгад хотын суурьшлын бүсэд судалгааны ажлыг эхлэх, Хангайн халуун рашаан геотермийн судалгааг эхлэнэ. | хэрэгжүүлэхээр ЭР геоэкологи-2019, ДА геоэкологи-2020, ХО геоэкологи-2021 болон Хангай, Хөвсгөл, Хэнтийн районы халуун рашааны геотермийн Гүний хагарал-1 нэртэй төслийн төсөв, төлөвлөгөөг УУХҮСайдын 2022 оны А/29 дүгээр тушаалаар батлан ажлыг эхлүүлсэн.<br>2.Төслүүдийн 2022 оны хээрийн болон суурин боловсруулалтын ажлын хэмжээ, арга, аргачлалыг ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлэн УУХҮСайдын шийдвэрээр баталгаажуулахаар ажиллаж байна.<br>3.2022 онд Улаанбаатар болон Эрдэнэт хотын эзэмшил газарт хийгдсэн судалгааны ажлын үр дүнг хүлээн авахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. | 50 |
| 26 | | 7. Геологийн өв, тулгуур зүсэлт, онцлог тогтоц, тектоник, минерагенийн болон геохими, геофизик, энергийн түүхий эдийн хэтийн төлөвийн сэдэвчилсэн судалгааны ажил хийнэ | 2021 - 2024 | УУХҮЯ | Улсын төсөв Батлагдсан: 2,280.2 Гүйцэтгэл: 102.1 Санхүүжилт: 50.2 | Тек-2021, ТЗ-2021 төслийг үргэлжлүүлэх, энергийн түүхий эдийн хэтийн төлөв /ЭТЭ-2022/ төслийг эхлүүлнэ. | 1. 2022 онд Монгол орны нутаг дэвсгэрийн хэмжээнд тархсан Мезозой, Кайнозойн насны хурдас чулуулгийн тархалт, тогтоц, түүнтэй холбоотой үүссэн ашигт малтмалын минерагенийн судалгааны Мезо-Кайнозой-2021 болон шинээр хэрэгжүүлэх Монгол Улсын босоо тэнхлэгийн дагуух нутгийг хамарсан геологийн орчин, тогтоцын судалгааны Геологийн орчин-2022, Баруун Монголын шатах ашигт малтмалын хэтийн төлөвийг тогтоох БМШАМ-2022, Монгол орны алтны металлогенийн зураг зохиох Мета-алт-500 төслийг төсөв, төлөвлөгөөг УУХҮСайдын 2022 оны А/29 дүгээр тушаалаар, геологийн даалгаврыг 2022.01.20-ны өдөр УУХҮ-ийн Дэд сайд баталсан.<br>2 Мезо-Кайнозой-2021 төслийн хээрийн болон суурин боловсруулалтын ажлын хэмжээ, арга аргачлалыг ЭБМЗ-ийн хуралдаанаар 3-р сард хэлэлцүүлсэн.<br>3. Геологийн орчин-2022, БМШАМ-2022, Мета-алт-500 төслийн гүйцэтгэгчийг шалгаруулах тендерийг Үндэсний геологийн алба нь "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн дагуу УУХҮСайдаас эрх шилжүүлсэнтэй холбоотойгоор гүйцэтгэж байна.<br>4. Төслүүдийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах зөвлөх үйлчилгээний тендерийг 2022.02.25-ний өдөр www.tender.gov.mn цахим системээр зарласан бөгөөд Мета-алт-500 төслийн тендерт хураангуй жагсаалтад багтсан оролцогч нарт 2022.04.06-ны өдөр тендерийн урилгыг хүргүүлж 2022.05.06-ны өдөр тендерийг нээсэн. Мета-алт- | 50 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 500 төслийн хамгийн сайн оролцогчоор шалгарсан хуулийн этгээдтэй зөвлөх үйлчилгээний гэрээг байгуулан ажлыг эхлүүлсэн.<br>5. Геологийн орчин-2022, БМШАМ-2022 хураангуй жагсаалт үүсээгүй тул тендерийг 2022.03.30-ны өдөр дахин зарласан. Хураангуй жагсаалтад багтсан оролцогч нарт 2022.05.11-ны өдөр тендерийн урилгыг хүргүүлж 2022.06.10-нд нээн хамгийн сайн оролцогчийг шалгаруулахаар ажиллаж байна. | |
| 27 | | 8. Гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх, ОХУ, БНХАУ, БНСУ, БНКазУ зэрэг гадаад орнуудтай хамтын ажиллагааны хүрээнд геологийн судалгааны ажил хийнэ | 2021 - 2024 | УУХҮЯ | Улсын төсөв Батлагдсан: 245.6 Гүйцэтгэл: 63.3 Санхүүжилт: 28.6 | ОХУ, БНХАУ, БНСУ, БНКазУ-тай хамтарсан геологийн судалгааны ажлын 5-р үе шатны ажлыг үргэлжлүүлэх, бусад орнуудтай харилцан үр ашигтай төсөл эхлүүлнэ. | МУ, ОХУ, БНХАУ, БНСУ, БНКазУ-ын хамтарсан төслийн 5-р үе шатны ажлын 2022 оны төсөв, төлөвлөгөөг УУХҮСайдын 2022 оны А/29 дүгээр тушаалаар батлуулж хээрийн болон суурин боловсруулалтын ажлыг эхлүүлсэн. | 90 |
| 28 | 3.2.4. Үндэсний геомэдээллийн нэгдсэн санг хөгжүүлж, цахим системийг нэвтрүүлж, төрийн үйлчилгээг түргэн шуурхай үзүүлнэ. | 1. Үндэсний геомэдээллийн нэгдсэн сан төслийг магматизм, стратиграф болон бусад геологийн мэдээллээр бүрдүүлэх, баяжуулах, мэдээлэл түгээх үйлчилгээг хялбаршуулна | 2021 - 2024 | УУХҮЯ | Улсын төсөв Батлагдсан: 700.0 Гүйцэтгэл: - Санхүүжилт: - | Үндэсний геомэдээллийн нэгдсэн сан хөтөлбөрийн төрөлжсөн мэдээллийн сан төслийг эхлүүлэх, ажлын явц 30%. | 1. 2022 оноос шинээр хэрэгжүүлж эхлэх Геологийн баримт-1-2022 төслийн төсөв, төлөвлөгөөг УУХҮСайдын 2022 оны А/29 дүгээр тушаалаар, геологийн даалгаврыг 2022.01.20-ны өдөр УУХҮ-ийн Дэд сайд баталсан.<br>2. Төслийн гүйцэтгэгчийг шалгаруулах тендерийг Үндэсний геологийн алба нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн дагуу УУХҮСайдаас эрх шилжүүлсэнтэй холбоотойгоор гүйцэтгэж байна.<br>3. Төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах зөвлөх үйлчилгээний тендерийг 2022.04.14-ний өдөр www.tender.gov.mn цахим системээр зарласан бөгөөд 2022.05.11-ний өдөр тендерийн урилгыг хураангуй жагсаалтад орсон 3 оролцогчид хүргүүлж 2022.06.10-ны өдөр тендерийг нээж хамгийн сайн оролцогчийг шалгаруулахаар ажиллаж байна. | 30 |
| 29 | | 2. Геологийн чулуун дээжийн сан болон цахим архивыг бүрдүүлэх, | 2021 - 2024 | УУХҮЯ | Улсын төсөв Батлагдсан: 550.0 Гүйцэтгэл: - | Геологийн чулуун дээжийн сан болон цахим архив | 1. 2022 оноос шинээр хэрэгжүүлж эхлэх Чулуун дээжийн сан-1-2022 болон Цахим архив-1-2022 төслийн төсөв, төлөвлөгөөг УУХҮСайдын 2022 оны А/29 дүгээр тушаалаар, геологийн даалгаврыг 2022.01.20-ны өдөр УУХҮ-ийн Дэд сайд баталсан. | 30 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | баяжуулах, мэдээлэл түгээх үйлчилгээг хялбаршуулна | | | Санхүүжилт: - | бүрдүүлэх төслийг эхлүүлэх, ажлын явц 60%. | 2. Төслийн гүйцэтгэгчийг шалгаруулах тендерийг Үндэсний геологийн алба нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн дагуу УУХҮСайдаас эрх шилжүүлсэнтэй холбоотойгоор гүйцэтгэж байна.<br>3. Төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах зөвлөх үйлчилгээний тендерийг 2022.04.14-ний өдөр www.tender.gov.mn цахим системээр зарласан бөгөөд хураангуй жагсаалт үүсээгүй тул тендерийг 2022.05.04-ний өдөр дахин зарласан. Хураангуй жагсаалт үүсгэн сонгон шалгаруулалтыг үргэлжлүүлэн ажиллаж байна. | |
| 30 | 3.2.5. Өндөр технологийн түүхий эд болох газрын ховор элемент, үнэт, өнгөт, хар, холимог металл, металл бус ашигт малтмал болон газрын тосны эрэл, хайгуулын ажлын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх замаар эрдэс баялгийн нөөцийг арвижуулна. | 1. Газрын ховор элемент болон өндөр технологийн түүхий эдийн суурь судалгааны ажил хийх, хэтийн төлөвийн үнэлгээ өгнө | 2021 - 2024 | УУХҮЯ | Улсын төсөв Батлагдсан: 1,087.3 Гүйцэтгэл: 53.6 Санхүүжилт: 27.3 | ГХЭ болон өндөр технологийн түүхий эдийн төрөлжсөн судалгааны төсөл хэрэгжүүлнэ. | 1. Стратегийн ашигт малтмал (ГАСАМ)-ын судалгааны ажлын үр дүнг цар тахлын нөлөөнөөс шалтгаалан 2021 онд хүлээн авах боломжгүй болсон бөгөөд 2022 онд хүлээн авахаар бэлтгэл ажлыг хангаж ажиллаж байна.<br>2. 2022 онд хэрэгжүүлэх өндөр технологийн түүхий эд /газрын ховор элемент/-ийн ӨТТЭ-1-2021 төслийн төсөв, төлөвлөгөөг УУХҮСайдын 2022 оны А/29 дүгээр тушаалаар батлан ажлыг эхлүүлсэн. Төслийн 2022 оны хээрийн болон суурин боловсруулалтын ажлын хэмжээ, арга, аргачлалыг ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлэн УУХҮСайдын шийдвэрээр баталгаажуулахаар ажиллаж байна.<br>3. Шинээр хэрэгжүүлж эхлэх өндөр технологийн түүхий эдийн судалгаа /ӨТТЭ-2-2022/-ны ажлын төсөв, төлөвлөгөөг УУХҮСайдын 2022 оны А/29 дүгээр тушаалаар, геологийн даалгаврыг 2022.01.20-ны өдөр УУХҮ-ийн Дэд сайд баталсан.<br>4. ӨТТЭ-2-2022 төслийн гүйцэтгэгчийг шалгаруулах тендерийг Үндэсний геологийн алба нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн дагуу УУХҮСайдаас эрх шилжүүлсэнтэй холбоотойгоор гүйцэтгэж байна.<br>5. Төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах зөвлөх үйлчилгээний тендерийг 2022.02.25-ны өдөр www.tender.gov.mn цахим системээр зарласан бөгөөд 2022.04.06-ны өдөр тендерийн урилгыг хураангуй жагсаалтад орсон 3 оролцогчид хүргүүлж 2022.05.06-ны өдөр тендерийг нээсэн. Хамгийн сайн оролцогчоор шалгарсан хуулийн этгээдтэй зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулан ажлыг эхлүүлсэн.<br>6. Газрын ховор элемент, литий-цезийн төрлөөр боловсруулах “Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангиллыг хэрэглэх аргачилсан зөвлөмж”-ийг боловсруулан хэрэглэж байна. | 90 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 31 | | 2. Үнэт, өнгөт, хар, ховор, холимог металл болон металл бус ашигт малтмалын нарийвчилсан, эрэл, үнэлгээний ажил хийх, хэтийн төлөвийн үнэлгээ өгнө | 2021 - 2024 | УУХҮЯ | Улсын төсөв Батлагдсан: 8,599.9 Гүйцэтгэл: 601.5 Санхүүжилт: 212.5 | Үнэт, ховор, холимог металлын чиглэлээр эрэл, үнэлгээний ажлын үр дүнг хүлээн авах, өнгөт, хар металлын судалгааг үргэлжлүүлэх, хэтийн төлөвийн үнэлгээ өгнө. | 1. Эрэл үнэлгээ-1-2020, Эрэл үнэлгээ-2-2021, Эрэл үнэлгээ-3-2021 болон БӨМ-Алт-2019 төслийн 2022 оны төсөв, төлөвлөгөөг УУХҮСайдын 2022 оны А/29 дүгээр тушаалаар, 2022 оны хээрийн болон суурин боловсруулалтын ажлын хэмжээ, арга, аргачлалыг ЭБМЗ-өөр хэлэлцсэн хуралдааны дүгнэлтийг үндэслэн УУХҮСайдын шийдвэрээр баталгаажуулахаар ажиллаж байна.<br>2. Төлөвлөгөөт онд шинээр хэрэгжүүлэх Эрэл үнэлгээ-4-2022 төслийн төсөв, төлөвлөгөөг УУХҮСайдын 2022 оны А/29 дүгээр тушаалаар, геологийн даалгаврыг 2022.01.20-ны өдөр УУХҮ-ийн Дэд сайдын тушаалаар баталсан.<br>3. Төслийн гүйцэтгэгчийг шалгаруулах тендерийг Үндэсний геологийн алба нь "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн дагуу УУХҮСайдаас эрх шилжүүлсэнтэй холбоотойгоор гүйцэтгэж байна.<br>4. Төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах зөвлөх үйлчилгээний тендерийг 2022.02.25-ний өдөр www.tender.gov.mn цахим системээр зарласан бөгөөд төслийн тендерт хураангуй жагсаалтад багтсан оролцогч нарт 2022.04.06-ны өдөр тендерийн урилгыг хүргүүлж 2022.05.06-ны өдөр тендерийг нээсэн. ЭҮ-4-2022 төслийн гүйцэтгэгчээр шалгарсан хуулийн этгээдтэй зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулан ажлыг эхлүүлсэн.<br>5. Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангиллыг тухайн төрлийн ашигт малтмалд хэрэглэх аргачилсан зөвлөмж (мөнгө, цагаан тугалга, хар тугалга-цайр, вольфрам, молибден)-ийг ХБНГУлсын Геошинжлэх ухаан, байгалийн нөөцийн холбооны хүрээлэн буюу BGR-ийн "Монгол Улсын эрдэс баялгийн салбар дахь институцын болон боловсон хүчний чадавхийг хөгжүүлэх-II" төслийн санхүүжилтээр ШУТИС-ийн ГУУС-ийн Эрдэс баялгийн судалгаа, геомэдээлэл, сургалтын төвийн эрдэмтэн, судлаачдаар гүйцэтгүүлсэн. Мөн Австрали-Монголын эрдэс баялгийн салбарын хамтын ажиллагааны хөтөлбөр AMEP-II-ын санхүүжилтээр бал чулуу, давс, карбонат чулуулаг, хөнгөн цагаан, лити-цези, элс хайрга, газрын ховор элементийн аргачилсан зөвлөмжийг Эрдэс баялгийн судалгаа, геомэдээлэл, сургалтын төвийн эрдэмтэн, судлаачдаар гүйцэтгүүлсэн. AMEP-II-ын санхүүжилтээр фосфат, манган, берилли, никель-кобальт, хромын хайгуулын ажилд хэрэглэх аргачилсан зөвлөмжийн төслийг 2021 оны 10 дугаар сараас эхлүүлсэн ба салбарын эрдэмтэдийн оролцоотойгоор боловсруулж байна. | 70 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 32 | | 3. Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олголтыг нэмэгдүүлж, хайгуулын ажлыг эрчимжүүлэн геологийн нөөцийг өсгөнө | 2021 - 2024 | УУХҮЯ, АМГТГ | Төсөв тусгагдаагүй | Ашигт малтмалын хайгуулын 60-80 тусгай зөвшөөрөл шинээр олгон, хайгуулын ажлыг эрчимжүүлж геологийн нөөцийг өсгөнө. | - Шинэчилэн батлагдсан “Тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журам”-ын дагуу хайгуулын тусгай зөвшөөрөл олгох боломжтой талбайн геологийн суурь мэдээллийг боловсруулсан. Монгол Улсын Ерөнхий сайдаас өгсөн чиглэлийн дагуу шинээр сонгон шалгаруулалт зарлах хугацааг хойшлуулаад байна.<br>Журам шинэчилэн батлагдахаас өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан журмын дагуу 2022 онд 121,503 га талбай бүхий ашигт малтмалын хайгуулын 50 тусгай зөвшөөрлийг олгож Улсын төсөвт 13.9 тэрбум төгрөг төвлөрүүлээд байна.<br>Ашигт малтмалын хайгуулын ажлын 50 тайланг ЭБМЗ-ийн салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн алт /үндсэн/ 1,004.39 мян.тн/кг металлаар, алт /шороо/ 559.42 кг металлаар, зэс 10,702.9 мян.тн/тн металлаар, төмөр 40,488.25 мян.тн хүдрээр, хайлуур жонш 1,095.77 мян.тн хүдрээр, нүүрс 16.26 сая тн, шохойн чулуу 50,516.54 мян.тн, дайрга 24.1 сая м3, боржин 8,294.67 мян.м3, кварц 1,855.19 мян.тн, гантиг 423.51 мян.м3, элсэн чулуу 7,991.19 мян.м3, элс 4,359.92 мян.м3, шавар 5,736.63 мян.м3, элс-хайрга 3,333.92 мян.м3-ийг улсын нэгдсэн санд бүртгэн нөөцийг өсгөсөн. | 90 |
| 33 | 3.2.6. Уул уурхайн салбарын институцийг бэхжүүлж, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, лиценз олголтыг олон нийтэд нээлттэй болгож, хууль зөрчиж олгосон зөвшөөрлийг хүчингүй болгоно. | 1. Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олголтыг цэгцэлж, олон нийтэд нээлттэй болгоно. | 2020 - 2022 | УУХҮЯ, УУБГ, ГБГ | Төсөв тусгагдаагүй | Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцүүлж шийдвэрлүүлэх. 100 хувь. | - УУХҮСайдын 2020.12.25-ны өдрийн А-332 дугаар тушаалаар Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн холбогдох судалгааг хийх, хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан.<br>Ажлын хэсгийн зүгээс Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу “хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх аргачлал”, хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төсөл болон хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ, хуулийн төслийн зардлын тооцоо зэргийг эцэслэн боловсруулсан.<br>Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлалын төсөлд мэргэжлийн холбоод болон аж ахуйн нэгж байгууллагаас санал авах хэлэлцүүлгийг зохион байгуулж холбогдох саналын авч ажиллаж байна.<br>- УУХҮСайдын 2022 оны А/67 дугаар тушаалаар “Тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журам”-ыг батлан Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 5821 дугаарт бүртгүүлсэн.<br>Хайгуулын тусгай зөвшөөрлийн цахим системийн хөгжүүлэлтийг бүрэн хийж, төрийн худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn цахим хуудсанд байршуулан ашиглахад бэлэн болсон. | 70 |
| 34 | | 2. Уул уурхайн салбарын | 2020 - 2024 | УУХҮЯ, УУБГ | 2500.0 сая төгрөг | Засгийн газрын шийдвэрийн | Уул уурхайн судалгаа, хөгжлийн төв байгуулах талаар Засгийн газрын тогтоолын төсөл болон төрийн өмчит аж | 30 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | судалгаа шинжилгээний байгууллагыг нэгдсэн зохион байгуулалтад оруулах асуудлын хүрээнд яамны харьяанд аж ахуйн тооцоот газрыг бий болгоно. | | | | дагуу уул уурхайн салбарын судалгаа шинжилгээний байгууллагыг байгуулна.100 хувьд хүргэнэ. | ахуйн тооцоот газрын дүрмийн төслийг боловсруулсан бөгөөд холбогдох тооцоо, судалгааг яамны удирдлагад танилцуулсан. | |
| 35 | | 3. Орон нутагт эрдэс баялгийн асуудал хариуцсан нэгж байгуулна. | 2021 - 2024 | УУХҮЯ, УУБГ | 818.6 сая төгрөг | Засгийн газрын шийдвэрийн дагуу орон нутагт эрдэс баялгийн асуудал хариуцсан нэгж байгуулагдана. 100 хувьд хүргэнэ. | Орон нутагт эрдэс баялгийн нэгж байгуулах ажлын хүрээнд эхний ээлжинд Өмнөговь, Дорноговь, Дорнод, Ховд, Орхон аймгуудад байгуулахаар "Зарим аймагт Эрдэс баялгийн нэгж байгуулах тухай" Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр хүргүүлсэн бөгөөд Санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг заавал авсны дараа хэлэлцүүлэхээр буцаасан. Сангийн яамны саналыг үндэслэн дахин боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр хүргүүлсэн. | 30 |
| 36 | | 4. Шинэ бүтээн байгуулалтын ажилд зайлшгүй шаардлагатай хүний нөөцийг бэлтгэх, мэргэшүүлэх ажлыг хамтын ажиллагааны хүрээнд холбогдох яам, байгууллагатай зохион байгуулна. | 2021 - 2024 | УУХҮЯ, УУБГ, ГБГ | Төсөв тусгагдаагүй | | Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого Алсын хараа-2050 болон Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан томоохон төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд шаардлагатай 2021 оны ажиллах хүчний мэдээлэл болон уул уурхай, хүнд үйлдвэр, газрын тосны салбарт үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүдэд тухайн төслийн техник, технологийн шаардлагаас хамаараад зарим мэргэжлийн инженер, техникийн гадаад ажиллах хүч, мэргэжилтэн шаардлагатай байдаг бөгөөд хүсэлтийг тус яамнаас Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн. Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарт мэргэжилтэн, боловсон хүчин бэлтгэдэг Их, дээд сургуулиудын нэг болох Монгол-Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургууль (МГТИС)-д бэлтгэгддэг Байгалийн нөөц, технологийн магистр /Master in Resources and Technology/-ын хөтөлбөрт тохирох индекс одоогоор байхгүй байгаа тул тохирох хөтөлбөрийн нэр, индексийг жагсаалтад бүртгүүлэх хүсэлтийг БШУЯ-нд хүргүүлсэн.<br>Газрын тос боловсруулах үйлдвэрт шаардлагатай инженер, техникийн ажиллагсадыг бэлтгэх ажлын хүрээнд ШУТИС, МУИС-иудтай хамтран сургалтын төлөвлөгөөг боловсруулж ШУТИС-ийн "Хөтөлбөрийн дэд хороо", "Хөтөлбөрийн ерөнхий хороо"-гоор хэлэлцүүлэн Боловсролын магадлан | 70 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | итгэмжлэлийн үндэсний зөвлөлийн хөтөлбөрийн урьдчилсан магадлан итгэмжлэлд оруулаад байна.<br>Мөн “Газрын тосны инженерчлэл” бакалаврын хөтөлбөрт БШУ-ны сайдын 2022.05.09-ний өдрийн А/160-р тушаалаар 072407 тоот индекс авсан. Энэхүү хөтөлбөрийг 2022-2025 онуудад хэрэгжүүлэх бөгөөд 2022-2023 онд инженерийн чиглэлээр элссэн оюутнуудыг 4 жилээр, инженерийн чиглэлээр сурч байгаа 2-р дамжааны оюутнуудыг 2.5 жилээр, инженерийн суурьтай төгсөгчдийг 2 жилээр сургах бөгөөд 2022 оны 9 сараас элсэлт авахаар төлөвлөж байна. Тусгай хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэхээр ажиллаж байна. | |
| 37 | 3.2.7. Хүнд үйлдвэрлэлийг хөгжүүлж, эрдэс түүхий эдийн боловсруулалтын түвшинг ахиулан, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ: | 1. Дархан-Сэлэнгийн бүсэд хар төмөрлөгийн цогцолборыг дэд бүтцийн хамт байгуулна. | 2021 - 2024 | УУХҮЯ, "Кью эс си" ХХК, "Дархан төмөрлөгийн үйлдвэр" ХК | | Төслийн удирдлага, инженеринг, тоног төхөөрөмжийн угсралт суурилуулалт, барилгын ажлыг эхлүүлнэ. 61.7% | “Эдийн Засаг Хөгжлийн Яам” /хуучнаар/ нь “Кью Эс Си” ХХК-тай 2014 онд байгуулсан “Уул уурхай, металлургийн цогцолбор байгуулах төсөл”-ийг хэрэгжүүлэх Концессын гэрээг ЗГ-ын 2022.04.13-ны өдрийн 148 дугаар тогтоолоор цуцалсан.<br>Дарханы төмөрлөгийн үйлдвэрийн захирлын түр орлон гүйцэтгэгч болон ТУЗ-ийг ТӨБЗГ-ын даргын тушаалаар томилж, үйлдвэрийг ТӨХК-ийн статустай болгож, үйл ажиллагааг жигдрүүлэх, төслийн хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх, хэрхэн үргэлжлүүлэх хувилбар боловсруулах зэрэг ажил хийгдэж байна.<br>Гэрээ цуцалсантай холбоотойгоор төслийн ажил түр зогсолтод ороод байгаа ба гэрээ цуцлах хүртэлх хугацаанд доорхи ажлууд хийгдсэн. Үүнд:<br>“Кью Эс Си” ХХК нь жилд 350 мян.тн ган бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадалтай “Монгол ган цогцолбор 1” төслийн ТЭЗҮ-ийг БНХАУ-ын “MCC-CERI”, Монгол Улсын “Кью Эм Си” ХХК-иудаар гүйцэтгүүлж ЭБМЗ-ийн 2021.09.30-ны өдрийн өргөтгөсөн хуралдаанаар хэлэлцүүлж, хүлээж авсан.<br>“Кью Эс Си” ХХК нь ТЭЗҮ-д туссан төсөл хэрэгжүүлэх хуваарийг нарийвчлан гаргаж 2022.02.16-ны өдрийн 9/22 дугаар албан бичгээр УУХҮЯ-нд ирүүлсэн.<br>Уг төлөвлөгөөний дагуу 2022 онд дараах ажлууд хийгдсэн. Үүнд: Төслийн зөвлөх компаниар Канад Улсын Хатч компанийг шалгаруулж, гэрээ байгуулсан.<br>Төмөртэйн ордын төмрийн хүдрийн дээжийг усан онгоцоор тээвэрлэн Канад улсын Монтреал хотод 2022 оны 03 сард хүргэн “Эс Жи Эс” лабораториор техниологийн туршилт хийлгэж эхэлсэн. Шинэ нойтон баяжуулах үйлдвэр, хорголжийн үйлдвэрийн концепцийн ажлын даалгаврыг төслийн зөвлөх компани болох Хатч компанитай хамтран боловсруулж, гадны компаниудаас үнийн санал авсан. | 30 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Шинэ цогцолбор үйлдвэрийн инженерингийн дизайны ажлын даалгаврыг Хатч компаниар хийлгэж хүлээн авсан. Мөн төслийн ТЭЗҮ-г боловсруулсан. Төслийн БОННҮ-г хийлгэхээр ажлын даалгаврын дагуу дотоодын 6 компаниас үнийн санал авч сонгон шалгаруулалтыг хийх ажил үргэлжилж байна.<br>Төслийн ажлыг эрчимжүүлэх ажлын хүрээнд УУХҮЯ-наас дараах ажлуудыг зохион байгуулсан.<br>2022.01.04-ны өдөр ХҮБГ-ын дарга Д.Даваадорж, 2022.01.08-ны өдөр УУХҮСайд Г.Ёндон нар “Кью Эс Си” ХХК-ийн удирдлагуудтай тус тус уулзалт хийж, төслийн хуваарийг нарийвлан гаргаж ирүүлэх, төслийн ажлыг эрчимжүүлэх, бүтээн байгуулалтын ажлыг 2022 онд эхлүүлэх зэрэг тодорхой үүрэг даалгаваруудыг өгч, протоколжуулсан. | |
| 38 | | 2. Орхон аймагт Эрдэнэтийн төмөрлөгийн үйлдвэрийг ашиглалтад оруулна. | 2020 - 2022 | УУХҮЯ, "Бэрэн групп" ХХК | | Барилга, дэд бүтцийн ажлыг дуусгаж тоног төхөөрөмжийн худалдан авалт, угсралт, суурилуулалтын ажлыг гүйцэтгэнэ. 100% | 2014 оноос Орхон аймагт хэрэгжүүлж байгаа “Бэрэн групп” ХХК-ийн 200 мян.тн/жил хүчин чадалтай ган бүтээгдэхүүний үйлдвэрийн төслийн хэрэгжилт 75 орчим хувьтай байна. Тус компани нь Монгол Улсын Хөгжлийн банкнаас 2014 онд 22.7 сая ам.доллар, 2018 онд 4.5 сая ам.доллар, нийт 27.2 сая ам.долларын зээлийн санхүүжилт авсан ба үйлдвэр ашиглалтад орж үйл ажиллагаа эхлүүлээгүйн улмаас уг зээл эргэн төлөгдөөгүй байна. Цаашид үйлдвэрийг ашиглалтанд оруулахад шаардагдах 30.7 тэрбум төгрөгийн санхүүжилтийг нэмж олгох хүсэлтийг тус компаниас Хөгжлийн банк болон УУХҮЯ-нд гаргасан ба УУХҮЯ болон Хөгжлийн банкны зүгээс боломжит хувилбарыг судалж байна. Мөн УУХҮЯ болон Хөгжлийн банкны хооронд “Төмөрлөг боловсруулах үйлдвэрийн төслийг бүрэн хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүгийн болон технологийн өдөр тутмын хяналтыг хийх зорилго бүхий 2021.12.28-ны өдрийн DBM/01/64 дугаар хамтран ажиллах санамж бичгийг байгуулсан.<br>ХҮБГ-аас 2022 онд төслийн талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ: 2022.01.04-ний өдөр УУХҮСайдад “Бэрэн групп” ХХК-ийн Орхон аймагт хэрэгжүүлж байгаа “Эрдэнэтийн төмөрлөгийн үйлдвэр”-ийн төслийн явц, тулгамдаж байгаа асуудлын талаар тус компанийн захирал Б.Мөнхтөр танилцуулсан. УУХҮСайдаас үйлдвэрийг ашиглалтад оруулах календарчилсан төлөвлөгөө гарган шахуу тооцоотой ажиллаж үйлдвэрийг яаралтай ашиглалтад оруулах үүрэг даалгавар өгсөн.<br>Дээрх ажлын хүрээнд тус төсийн санхүүжилтыг шийдвэрлэх, үйлдвэрийг ашиглалтад оруулах асуудлаар Хөгжлийн банкны холбогдох удирдлагуудтай удаа дараагийн уулзалтуудыг ХҮБГ-аас зохион байгуулан ажиллаж байна. | 30 |
| 39 | | 3. Дорноговь аймагт хар | 2020 - 2023 | УУХҮЯ, "МДМУ" ХХК | | Гангийн үйлдвэрийн | МДМУ ХХК-ийн хэрэгжүүлж буй хар төмөрлөгийн цогцолбор үйлдвэр байгуулах төслийн ажил ковид-19 цар тахлын | 0 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | төмөрлөгийн цогцолбор үйлдвэр байгуулна. | | | | барилгын ажил, тоног төхөөрөмж татан авалт, угсралтын ажлыг гүйцэтгэж, түүхий эдийг татан авч нөөцлөнө. 88% | улмаас 2020-2022 оны 06 дугаар сарын байдлаар зогсонги байдалд байна. Төслийн санхүүжилт толгой компани /"Монзол групп" ХХК/-ийн хөрөнгө оруулалтаар шийдэгдсэн. Цутгуурын цех, дулаан боловсруулах цехийн шаардлагатай тоног төхөөрөмжүүдийн захиалга хийгдэж, 3.567 тэрбум төгрөгийн урьдчилгааг төхөөрөмж нийлүүлэгч компанид төлсөн боловч төлөвлөгөөний дагуу БНХАУ /"Qianxi ADI Machanical Casting" Co.Ltd компани/-д очиж газар дээр нь тоног төхөөрөмжийн сонголт хийн оруулж ирэх, мөн мэргэжилтэн оруулж ирэх асуудал хилийн хөл хорионы улмаас шийдэгдэхгүй байна. | |
| 40 | | 4. "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ыг түшиглэн "Уул уурхай-металлурги-химийн үйлдвэрийн цогцолбор" үйлдвэрлэл, технологийн парк байгуулна. | 2020 - 2022 | УУХҮЯ, "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ | | ҮТП-ийн авто зам, дулаан, ус хангамж, цахилгаан хангамж, төмөр зам, ариутгах татуургын сүлжээг барьж байгуулна. 100% | "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ыг түшиглэн "Уул уурхай-металлурги-химийн үйлдвэрийн цогцолбор" үйлдвэрлэл, технологийн парк байгуулах ажлын явц дараах байдалтай байна. Үүнд:<br>Автозам: Зураг төслийн ажил 100%<br>Төмөр зам: Зураг төслийн ажил 100%<br>Усан хангамж, ариутгал татуургын систем:<br>Зураг төслийн ажил 100%<br>Цахилгаан хангамжийн ТЭЗҮ 100%<br>"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ нь батлагдсан зураг төсөл хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу ҮТП-ийн дэд бүтцийг барьж байгуулах ажлын гүйцэтгэгчийг сонгох тендер шалгаруулалт эхэлсэн. | 30 |
| 41 | | 5. "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын ҮТП байгуулах ажлын хүрээнд Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийг барина. | 2020 - 2024 | УУХҮЯ, "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар | | Үйлдвэрийн барилгын ажлыг эхлүүлж, тоног төхөөрөмжийн худалдан авалтыг хийнэ. 50% | УУХҮСайдын 2022.05.12-ны өдрийн А/103 дугаар тушаалаар "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ыг түшиглэн байгуулах үйлдвэрлэл, технологийн паркийн Зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэрийн ТЭЗҮ-д шүүмж дүгнэлт гаргах үүрэг бүхий Шинжээчийн хэсэг байгуулагдан ажилласан.<br>2022.06.22-ны өдөр УУХҮЯ-ны ЭБМЗ-ийн өргөтгөсөн хуралдаан болж "Зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэрийн ТЭЗҮ-ийг хэлэлцэн батлаад байна. | 30 |
| 42 | | 6. "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын ҮТП байгуулах ажлын хүрээнд Исэлдсэн хүдрийг нуруулдан уусгах үйлдвэр байгуулна. | 2020 - 2022 | УУХҮЯ, "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар | | Үйлдвэрийн барилгын ажлыг гүйцэтгэж дуусгана. 100% | УУХҮСайдын 2022.05.03-ны өдрийн А/91 дугаар тушаалаар "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын Эрдэнэтийн овоо зэс молибдены ордын исэлдсэн хүдрийг нуруулдан уусгах SX-EW технологиор жилд 10.0 мянган тонн катодын зэс үйлдвэрлэх үйлдвэрийн ТЭЗҮ-д шүүмж дүгнэлт гаргах үүрэг бүхий Шинжээчийн хэсэг байгуулагдан ажиллаж байна. | 30 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 43 | | 7. Үнэт металл цэвэршүүлэх үйлдвэрийг барьж байгуулна. | 2021 - 2024 | УУХҮЯ, "Эрдэнэс Алт ресурс" ХХК | | Үйлдвэрийн бүтээн байгуулалтын бэлтгэл ажлыг хангаж, тоног төхөөрөмж худалдан авалтыг хийнэ. 30% | БНКазУ-ын Сымбат инженеринг компанийн боловсруулсан үнэт металл цэвэршүүлэх үйлдвэрийн ТЭЗҮ, төслийн эдийн засгийн үр ашгийн тооцоолол, ижил төстэй үйлдвэрүүдийн харьцуулсан судалгаа, төслийн санхүүжилтийн талаар дүгнэлт гаргах үүрэг бүхий Ажлын хэсгийг "Эрдэнэс Монгол" ХХК-ийн гүйцэтгэх захирлын 2021 оны А/100 дугаар тушаалаар байгуулан ажиллаж Ажлын хэсгийн дүгнэлтийг Эрдэнэс Монгол ХХК-ийн Тэргүүн дэд захирал О.Хулангийн "Ажлын хэсгийн дүгнэлт хүргүүлэх тухай" 2021.12.09-ны өдрийн 03/678 дугаар албан бичгээр ирүүлсэн.<br>"Эрдэнэс Монгол" ХХК-ийн гүйцэтгэх захирлын 2021 оны А/100 дугаар тушаалаар байгуулагдсан Ажлын хэсгийн дүгнэлтийг нарийвчлан судалж, төслийг хэрэгжүүлэх чиглэлээр 2022 онд хийгдэх ажлын төлөвлөгөөг Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 3.2.7.7 дахь хэсэгт заагдсан арга хэмжээний төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулж, тус компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, баталгаажуулж ирүүлэх тухай ХҮБГ-ын даргын 2022.01.06-ны өдрийн 07/42 дугаартай албан бичгээр "Эрдэнэс алт ресурс" ХХК-д, Ажлын хэсгийн дүгнэлтийн дагуу төслийг хэрэгжүүлэх чиглэлээр 2022 онд гүйцэтгэх ажлын нарийвчилсан төлөвлөгөөг Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 3.2.7.7 дахь хэсэгт заагдсан арга хэмжээний төлөвлөгөөтэй уялдуулан гаргаж, баталгаажуулах, Үнэт металл цэвэршүүлэх үйлдвэрийг барьж байгуулах төслийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийг шийдвэрлэх болон төсөл хэрэгжүүлэгчийг нээлттэй сонгон шалгаруулах ажлыг 2022 оны нэгдүгээр улиралд багтаан зохион байгуулахаар тус төлөвлөгөөнд тусгаж хэрэгжилтийг ханган ажиллах тухай УУХҮСайдын 2022.01.06-ны өдрийн 01/43 дугаартай албан бичгийг "Эрдэнэс Монгол" ХХК-д хүргүүлсэн. Үнэт металл цэвэршүүлэх үйлдвэрийг барьж байгуулах олон улсын нээлттэй сонгон шалгаруулалтын ажлын даалгавар боловсруулах Ажлын хэсгийг "Эрдэнэс алт ресурс" ХХК-ийн захирлын тушаалаар байгуулан ажиллаж байна. | 30 |
| 44 | | 9. Оюутолгойн ордыг түшиглэн зэсийн баяжмалыг боловсруулах үйлдвэр байгуулах | 2021 - 2028 | УУХҮЯ | 4,267.9 | Нарийвчилсан ТЭЗҮ, БОННҮ, инженер, геологийн судалгааг хийнэ. 1% | Засгийн газрын 2017 оны 88 дугаар тогтоолоор "Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулахад хөрөнгө оруулж хамтран ажиллах хөрөнгө оруулагчийг сонгох, хөрөнгө оруулагчтай байгуулах гэрээний талаар хэлцэл хийх асуудлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Сангийн сайд, Үндэсний хөгжлийн газрын даргад тус тус даалгасны дагуу "Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр барих төслийн | 30 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | ажлыг эхлүүлнэ. | | | | | хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулах аргачлал" болон хөрөнгө оруулалтын гэрээний төслийг боловсруулж хамтран батлахаар СЯ болон ЭЗХЯ-нд хүргүүлсэн бөгөөд СЯ-наас хамтран батлах шаардлагагүй талаар хариу ирүүлсэн бол ЭЗХЯ-наас хариу ирүүлээгүй байна.<br>Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулах төсөлд "Оюутолгой"ХХК-иас хөрөнгө оруулж, хамтран ажиллах болон Хөрөнгө оруулалтын гэрээний 3.21-д заасан техникийн шалгуурууд болон үзүүлэлтүүдийн талаар саналаа ирүүлэх тухай УУХҮСайдын 2022.04.18-ны өдрийн 01/1085 дугаар албан бичгийг "Оюутолгой"ХХК-д хүргүүлсэн.<br>"Оюутолгойн ордыг түшиглэн зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулах" ажлыг эрчимжүүлэн, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх Ажлын хэсгийг "Эрдэнэс Оюутолгой" ХХК-иас байгуулж ажиллуулах хүрээнд Ажлын хэсэгт ажиллах ажилтнуудын нэрсийг УУХҮСайдын 2022.04.28-ны өдрийн 01/1233 дугаар албан бичгээр "Эрдэнэс Оюутолгой" ХХК-д, Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулах төсөлд хөрөнгө оруулж, хамтран ажиллах талаар тодорхой саналаа ирүүлэх тухай албан бичгийн УУХҮСайдын 2022.04.26-ны өдрийн 01/1179 дугаар албан бичгээр "Рио тинто Монгол" ХХК-д хүргүүлсний дагуу "Эрдэнэс Оюу толгой" ХХК-иас "Мэдээлэл хүсэх тухай", Рио тинто компаниас харилцан санал солилцох тухай албан бичгүүдийг тус тус ирүүлээд байна.<br>Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулах төслийн хүрээнд Эрдэнэс Оюутолгой ХХК-тай 2022.06.15-ны өдөр нууцлалын гэрээ байгуулж, төслийг хэрэгжүүлэх, санхүүжүүлэх хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулах аргачлалыг боловсруулах чиглэлээр судалгааны ажлыг эхлүүлээд байна. "Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн төсөл"-ийн хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх ажлын хүрээнд АНУ-ын хөрөнгө оруулагчдад танилцуулах ажлыг зохион байгуулсан. | |
| 45 | 3.2.8. Дотоодын түүхий эдэд тулгуурласан газрын тос боловсруулах үйлдвэрийг барьж байгуулна: | 1.1. Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтыг эрчимжүүлж нөөцийг өсгөнө. | 2020 - 2024 | УУХҮЯ,<br>АМГТГ | | Шинээр 3 талбайд БХГ байгуулсан байна. ГТ-ны олборлолт 834.3 мян.тн | Матад XX талбайн газрын тосны нөөцийг ЭБМЗ-өөр хэлэлцүүлэн батлуулж, газрын тосны баталгаат нөөц 338,78 сая тн, үүнээс ашиглалтын баталгаат нөөц 43,38 сая тн болсон. Газрын тосны хайгуулын талбайнуудад шинээр Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулж, хайгуулын ажлын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх бэлтгэл ажлыг хангаж байгаа бөгөөд гэрээлэгчгүй байгаа 10 хайгуулын талбайд хийгдсэн хайгуулын ажлын жагсаалтыг гаргуулаад байна.<br>2022.05.30-ны өдрийн байдлаар 37.5 мянган баррель буюу 5,147 тонн газрын тос олборлож, төлөвлөгөөний гүйцэтгэл | 30 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 0.6 хувьд хүрсэн. БНХАУ-ын Эрээн болон Зүүнхатавч хилийн боомтууд 2021.11.27-ны өдрөөс хойш ажиллаагүй тул тосны экспорт хийгдээгүй. | |
| 46 | | 1.2. Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул судалгааны ажил, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, хэтийн төлөв тодорхойлно | 2020 - 2024 | УУХҮЯ, АМГТГ | | Хайгуулын ажил, хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдсэн байна. | Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл хийх 12 гэрээ хэрэгжиж байна. Хайгуулын 10 талбайд төлөвлөгөө төсөв баталсан. Эдгээр талбайд 2022 оны төлөвлөгөөгөөр нийтдээ 33.5 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийгдэхээр байна. | 70 |
| 47 | | 1.3. Газрын тосны хайгуулын талбайнуудад шинээр Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулж, хайгуулын ажлын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ | 2020 - 2024 | УУХҮЯ, АМГТГ | | Шинээр 3 талбайд БХГ байгуулсан байна. | Газрын тосны хайгуулын талбайнуудад шинээр Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулж, хайгуулын ажлын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх бэлтгэл ажлыг хангаж байгаа бөгөөд гэрээлэгчгүй байгаа 10 хайгуулын талбайд хийгдсэн хайгуулын ажлын жагсаалтыг гаргуулаад байна. | 30 |
| 48 | | 1.4. Газрын тосны хайгуулын талбайд шинээр газрын тосны орд нээж, нөөц тогтоох ажлыг зохион байгуулна | 2020 - 2024 | УУХҮЯ, АМГТГ | | Гэрээлэгчдийн хайгуул, судалгааны ажлын үр дүнтэй уялдуулан нөөц тогтоох ажлыг зохион байгуулсан байна. | Газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудлаар 2022.04.27-ны өдрийн Засгийн газрын хуралдаанд танилцуулга хийж 25 дугаар тэмдэглэлийг гаргуулсан. Уг тэмдэглэлд газрын тос боловсруулах үйлдвэр барихтай холбогдуулан газрын тосны хайгуул, ашиглалтын бүтээгдэхүүн хуваах гэрээт талбайг хууль тогтоомжид заасны дагуу Монгол Улсын газрын нэгдмэл санд бүртгэх, газар ашиглах гэрчилгээ олгох арга хэмжээ авч ажиллахыг БХБСайд Б.Мөнхбаатарт, газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагааг хууль тогтоомжид заасан бүрэн эрхийн хүрээнд дэмжиж ажиллахыг бүх шатны Засаг дарга нарт даалгасан.<br>Газрын тосны хайгуулын талбайнуудад цаашид нөөц тогтоох боломжтой Галба-11, Тариач-15, Баянтүмэн-17, Хөх нуур-18, Давст-31, Ар булаг-29 талбайн мэдээллийг 2022.05.18-ны өдрийн Засгийн газрын ээлжит бус цахим хуралдаанд танилцуулан Ерөнхий сайдын захирамж гаргахаар тогтсон. | 90 |
| 49 | | 1.5. Газрын тосны ордын ашиглалт, | 2020 - 2024 | УУХҮЯ, АМГТГ | | ГТ-ны олборлолт 834.3 мян.тн | 2021.11.28-ны өдөр БНХАУ-ын талаас хилийн боомтуудыг хаасан бөгөөд 2022.06.13-ны байдлаар газрын тосны экспортын үйл ажиллагаа явагдаагүй байна. Газрын тосны | 30 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | олборлолтыг урт хугацаанд тогтвортой хадгалж, боломжит хэмжээгээр нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулж, дэмжлэг үзүүлнэ | | | | | экспортын үйл ажиллагааг эхлүүлэх, хилийн боомтуудыг нээлгэх талаар Улсын онцгой комисс болон Гадаад харилцааны сайд нарт 2022.04.08-ны өдөр 1/935 тоот албан бичгийг хүргүүлсэн. Хилийн боомтууд нээгдээгүй байна. Газрын тосны ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй Петрочайна Дачин Тамсаг ХХК-ийн нийгмийн даатгал, татварын асуудлаар болон газрын тосны нөөцийн талаарх танилцуулгыг УИХ-ын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдаанд танилцуулан Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээнээс Монгол Улсын хүртэх үр ашгийг нэмэгдүүлэх тухай 2022.05.24-ний өдрийн 03 тоот тогтоол гаргуулсан. Мөн ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй Тосон-Уул-19 болон Тамсаг-21 дүгээр талбайн БХГ-г хууль тогтоомжид нийцүүлэн шинэчлэх талаар 2022.05.19-ний өдрийн 78 дугаар Ерөнхий сайдын захирамж гарч Ажлын хэсгийг Шадар сайд С.Амарсайханаар ахлуулан ажиллаж байна. | |
| 50 | | 2.1. Газрын тос боловсруулах үйлдвэрийг түүхий эдээр хангах, дамжуулах хоолой барих санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэж, бүтээн байгуулалтын ажлыг гүйцэтгэнэ. | 2020 - 2024 | УУХҮЯ,<br><br>АМГТГ | | Дамжуулах хоолойн инженер техникийн зураг төслийг боловсруулах, батлуулах ажлыг зохион байгуулж,барилга угсралтын ажлыг эхлүүлсэн байна. 40% | УУХҮЯ-ны ТНБДаргын 2021 оны А/08 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг олон улсын сонгон шалгаруулалтыг явуулж БНХАУ-ын Норинко интернейшнл компанийг шалгаруулсан. Шалгарсан компанитай гэрээ байгуулах талаар ЗГ-ын 2022.03.02-ны өдрийн 14 дүгээр тэмдэглэл, 94 дүгээр тогтоолыг тус тус гаргуулж, хоолойн байгууламж барихад шаардагдах санхүүжилтийг нүүрс урьдчилан борлуулах замаар санхүүжүүлэхээр шийдвэрлсэн. Үүний дагуу Төслийн захиалагч Монгол Улсын Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, төслийн санхүүжүүлэгч “ЭТТ” ХК, төсөл хэрэгжүүлэгч “МГТБҮ” ТӨХХК болон төслийн гүйцэтгэгч БНХАУ-ын төрийн өмчит Норинко компаниудын хооронд 2022.04.18-ны өдөр Хамтран ажиллах гэрээг, “МГТБҮ” ТӨХХК болон “Норинко” компанийн хооронд 2022.04.21-ний өдөр дамжуулах хоолойн инженерчлэл, худалдан авалт, барилга угсралтын ажил гүйцэтгэх (EPC) гэрээ, “МГТБҮ” ТӨХХК болон “ЭТТ” ХК-ийн хооронд 2022.04.22-ны өдөр дамжуулах хоолойн барилга угсралт, бүтээн байгуулалтын ажлын санхүүжилтийн гэрээг, “ЭТТ” ХК болон “Норинко” компанийн хооронд 2022.04.22-ны өдөр нүүрс худалдах, худалдан авах гэрээг тус тус байгуулсан. “МГТБҮ” ТӨХХК болон “Норинко” компанийн хооронд байгуулсан, дамжуулах хоолойн инженерчлэл, худалдан авалт, барилга угсралтын ажил гүйцэтгэх (EPC) гэрээний хүрээнд зураг төслийн ажил хийгдэнэ. | 30 |
| 51 | | 2.3. Дамжуулах хоолой барих төслийн ТЭЗҮ, | 2020 - 2024 | | | Дамжуулах хоолойн инженер | “МГТБҮ” ТӨХХК болон “Норинко” компанийн хооронд байгуулсан, дамжуулах хоолойн инженерчлэл, худалдан авалт, барилга угсралтын ажил гүйцэтгэх (EPC) гэрээний | 30 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | инженер техникийн зураг төслийг боловсруулах батлах, барилга угсралт, бүтээн байгуулалтын ажлыг зохион байгуулна | | | | техникийн зураг төслийг боловсруулах, батлуулах ажлыг зохион байгуулж,барилга угсралтын ажлыг эхлүүлсэн байна. 40 % | хүрээнд зураг төслийн ажил хийгдэнэ. Төслийн хүрээнд 2022 онд хоолойн трассын дагуух газрыг тусгай хэрэгцээнд авах, трассын дагуу инженер геологийн судалгаа хийх, хоолойн нарийвчилсан зураг төсөл боловсруулах, хоолойг барьж байгуулах ажилчдын амьдрах түр кемпүүд, агуулах, насос станцуудын хашаа, барилгын суурь болон бусад дэд бүтцийн ажлуудыг хийхээр төлөвлөж байна. | |
| 52 | | 3.1. Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт дотоодын түүхий эдэд тулгуурласан газрын тос боловсруулах үйлдвэрийг барьж байгуулна. | 2020 - 2024 | | | 2020-2021 онд хийж эхэлсэн барилга угсралтын ажлуудыг дуусгаж, лицензит байгууламжийн барилга угсралтын ажлыг эхлүүлсэн байна. 60% | Технологийн бус барилга байгууламжийн ажил /EPC-1/-ын барилга угсралтын ажлын гүйцэтгэл 2022.06.01-ний өдрийн байдлаар **59,6**%-тай байна. Эдгээрт Түүхий ус хадгалах сав-70%, Оффис, сургалтын төв-31%, Хоолны газар-74%, Лаборатори-78%, Анхны тусламж, эмнэлгийн барилга-76%, Агуулах-33,2%, Нэвтрэх хаалга-1-53%, Нэвтрэх хаалга-2-33%, Гал унтраах командын барилга-36%, Засварын цех-27%, Үерийн ус цуглуулах талбай-82,5%, Ус зайлуулах хоолой-17,18%, Ус дамжуулах хоолой-89%, 17км авто зам-26%, Ус дамжуулах хоолой-/Бор хөөвөр/-34%, 11 худаг-36,5%, Цахилгаан дамжуулах агаарын шугам-65%-ийн тус тус гүйцэтгэлтэй. EPC-1 багц ажилд шаардлагатай бараа материалыг далай болон төмөр замаар БНЭУ-аас авчирч буй бөгөөд 102 вагон бараа материал (3023 тн арматур, 20102 м бетон хоолой, 86622 м ган хоолой, 343171 ш блок)-ыг үйлдвэрийн талбайд буулгасан ба худалдан авалт 72,0%-тай байна.<br>Лицензгүй технологийн байгууламжийн ажил /EPC-2/-ын ерөнхий гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг 2021.12.30-нд, Үйлдвэрийн цахилгаан станцын ажил /EPC-3/-ын тендерийг 2022.02.09-нд тус тус хүлээн авсан. Тендерт босго үнээс давсан үнийн санал ирсэн тул Энэтхэгийн талтай яриа хэлэлцээ хийж, түргэвчилсэн тендер шалгаруулалт зохион байгуулахаар шийдвэрлэсэн. EPC-3 багц ажлын тендерийн материалд холбогдох өөрчлөлтийг оруулан 2022.04.20-ны өдөр "Тендерийн өмнөх уулзалт"-ыг зохион байгуулж, "Түргэвчилсэн тендер"-ийг 2022.05.04-нд зарлаж, эхний компаниуд Монголд ирж ажиллах нөхцөл, хууль эрх зүйн орчин, техник, тоног төхөөрөмж, бараа материал нийлүүлэх боломж, ажиллах хүчний байдалтай танилцаж эхлээд байна. EPC-2 багц ажлын "Тендерийн өмнөх уулзалт"-ыг 2022.05.17-нд зохион байгуулж 2022.06.06-ны өдөр тендерийг зарласан. | 70 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Лицензтэй технологийн байгууламжуудыг барих ажил /EPC-4/-ын лиценз эзэмшигчдийг шалгаруулсан. Устөрөгчийн байгууламжийн лиценз эзэмшигч Итали улсын Кинетикс технологи компани, Хүхэр ялгах байгууламжийн лиценз эзэмшигч Франц улсын Аксенс компани, Бензин боловсруулах, Гидрокрекинг, Дизелийн гидроцэвэрлэгээ, Шингэрүүлсэн шатдаг хий ялгах байгууламжуудын лиценз эзэмшигч АНУ-ын ЮүӨүПи Хонивэлл компанитай тус тус гэрээг байгуулаад байна. | |
| 53 | | 3.2. Газрын тос боловсруулах үйлдвэрийг дэмжих тухай хуулийн төсөл боловсруулж, батлуулах ажлыг зохион байгуулна | 2020 - 2024 | | | Хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллана. | Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Эксим банк хооронд байгуулсан “Зээлийн ерөнхий хэлэлцээр”-ийн хүрээнд хэрэгжүүлж буй газрын тос боловсруулах үйлдвэрийг төлөвлөсөн хугацаанд багтаан барьж байгуулах, төслийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, төрөөс үзүүлэх дэмжлэгийг тодорхойлох, эрхзүйн зохицуулалтыг бий болгох зорилгоор “Газрын тос боловсруулах үйлдвэрийг дэмжих тухай” хуулийн төслийг УИХ-ын чуулганы 2021.01.29-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүж батлуулсан. Мөн хуулийн 3.3 дахь хэсэгт заасан Газрын тос боловсруулах үйлдвэрт төрөөс дэмжлэг үзүүлэх журмыг ЗГ-ын 2021.08.11-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор батлуулсан. | 100 |
| 54 | | 3.3.Үйлдвэрийн барилга угсралт, бүтээн байгуулалтын ажлыг төлөвлөгөөний дагуу гүйцэтгэх ажлыг зохион байгуулж, дэмжлэг үзүүлнэ | 2020 - 2024 | | | 2020-2021 онд хийж эхэлсэн барилга угсралтын ажлуудыг дуусгаж, лицензит байгууламжийн барилга угсралтын ажлыг эхлүүлсэн байна. 60% | Лицензгүй технологийн байгууламжийн ажил /EPC-2/-ын ерөнхий гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг 2021.12.30-нд, Үйлдвэрийн цахилгаан станцын ажил /EPC-3/-ын тендерийг 2022.02.09-нд тус тус хүлээн авсан. Тендерт босго үнээс давсан үнийн санал ирсэн тул Энэтхэгийн талтай яриа хэлэлцээ хийж, түргэвчилсэн тендер шалгаруулалт зохион байгуулахаар шийдвэрлэсэн. EPC-3 багц ажлын тендерийн материалд холбогдох өөрчлөлтийг оруулан 2022.04.20-ны өдөр “Тендерийн өмнөх уулзалт”-ыг зохион байгуулж, “Түргэвчилсэн тендер”-ийг 2022.05.04-нд зарлаж, эхний компаниуд Монголд ирж ажиллах нөхцөл, хууль эрх зүйн орчин, техник, тоног төхөөрөмж, бараа материал нийлүүлэх боломж, ажиллах хүчний байдалтай танилцаж эхлээд байна. EPC-2 багц ажлын “Тендерийн өмнөх уулзалт”-ыг 2022.05.17-нд зохион байгуулж 2022.06.06-ны өдөр тендерийг зарласан.<br>Лицензтэй технологийн байгууламжуудыг барих ажил /EPC-4/-ын лиценз эзэмшигчдийг шалгаруулсан, Устөрөгчийн байгууламжийн лиценз эзэмшигч Итали улсын Кинетикс технологи компани, Хүхэр ялгах байгууламжийн лиценз эзэмшигч Франц улсын Аксенс компани, Бензин боловсруулах, Гидрокрекинг, Дизелийн гидроцэвэрлэгээ, Дизелийн гидроцэвэрлэгээ, Шингэрүүлсэн шатдаг хий ялгах | 50 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | байгууламжуудын лиценз эзэмшигч АНУ-ын ЮүӨүПи Хонивэлл компанитай тус тус гэрээг байгуулаад байна. | |
| 55 | | 3.4. Газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн тогтвортой байдлыг хангах ажлыг зохион байгуулна | 2020 - 2024 | | | Шатахууны хангамж тогтвортой байна. 2.2 сая тонн | Газрын тосны бүтээгдэхүүн импортлох, бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий нийт 217 аж ахуйн нэгж улсын хэмжээнд шатахууны 89 агуулах, 1469 шатахуун түгээх станцаар дамжуулан бүтээгдэхүүний хангамж, борлуулалтын үйл ажиллагаа эрхэлж байна. Монгол Улсын хэмжээнд оны эхнээс 2022 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн байдлаар нийт 765,3 мянган тонн газрын тосны бүтээгдэхүүн импортлон хэрэглэсэн бөгөөд үүний 92.2 хувийг ОХУ, 4.2 хувийг БНХАУ улс, 3.6 хувийг бусад улсаас нийлүүлсэн. Засгийн газрын 2021 оны 311 дүгээр тогтоолоор 2022 онд газрын тосны бүтээгдэхүүн импортлох, бөөний худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй нэр бүхий 28 аж ахуйн нэгж 193,500 тонн компанийн нөөц бүрдүүлэхээр баталсан. Тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд АМГТГ тус аж ахуйн нэгжүүдтэй гэрээ байгуулан, нөөцийн бүрдүүлэлтэд тухай бүр хяналт тавьж ажиллаж байна. 2022 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн байдлаар улсын хэмжээнд А-80 автобензин 72, Аи-92 автобензин 36, Аи-95 автобензин 51, дизелийн түлш 28, ТС-1 65 хоногийн нөөцтэй байна.<br>Газрын тосны бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангах, шатахуун худалдан авах урт хугацааны гэрээний хэрэгжилтийг дүгнэх ажлын хүрээнд 2022 оны 4 дүгээр сарын 26-ны өдрөөс 29-ний өдрүүдэд ОХУ-ын Москва хотноо УУХҮЯ, АМГТГ, НИК, Шунхлай, М-Ойл, Лекс Ойл, Магнай Трейд зэрэг аж ахуй нэгжүүдийн төлөөлөл Роснефть компанитай уулзалт зохион байгуулсан. Тус уулзалтаар импортлогч аж ахуйн нэгжүүд болон Роснефть компани хооронд байгуулсан урт хугацааны гэрээний хэрэгжилт, захиалгын тоо, хэмжээ, чанар стандарт, үнийн асуудлаар холбогдох саналуудыг хэлэлцсэн. Оросын талтай хийсэн энэхүү уулзалт, хэлэлцээрийн үр дүнд эхний хагас жилийн байдлаар газрын тосны бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлт хэвийн байна.<br>Импортын бусад эх үүсвэрийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Засгийн газрын 2022 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 53 дугаар тогтоолоор “Газрын тосны бүтээгдэхүүний импортын олон талт эх үүсвэрийг нэмэгдүүлэх, хангамжийн тогтвортой байдлыг хангах зорилгоор хилийн Гашуунсухайт, Шивээхүрэн боомт орших улсын хилийн зурваст газрын тосны бүтээгдэхүүн шилжүүлэн ачих байгууламж, агуулах барих зориулалтаар газар ашиглах” шийдвэр гарсан. Үүний дагуу УУХҮСайдын 2022 оны 4 дүгээр сарын 05-ны өдрийн А/60 дугаар тушаалаар Өмнөговь аймгийн Гашуунсухайт, | 90 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Шивээхүрэн боомт орчмын хилийн зурваст газрын тосны бүтээгдэхүүний шилжүүлэн ачих агуулахын байгууламжийг өөрийн хөрөнгөөр барьж байгуулах гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдаж, сонгон шалгаруултыг зохион байгуулсан. Гашуунсухайт болон Шивээхүрэнгийн боомтын шилжүүлэн ачих агуулахын байгууламжийн төслийг “Шунхлай групп” ХХК өөрийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр шалгарч, УУХҮЯ-тай хамтран ажиллах тухай 2022 оны №21, №22 тоот гэрээг байгуулан үйл ажиллагаагаа эхлүүлээд байна. Энэхүү төсөл хэрэгжиж, газрын тосны бүтээгдэхүүний шилжүүлэн ачих агуулах, байгууламж ашиглалтад орсноор уул уурхайн үйл ажиллагаа эрчимтэй өрнөж буй өмнөд бүсийн шатахууны хангамжийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх, жил бүр өсөн нэмэгдэж буй тус бүс нутгийн хэрэглээг тогтвортой хангах нөхцөл бүрдэх юм.<br>Мөн шатахууны хил үнийн өндөр өсөлттэй холбоотой аж ахуйн нэгжүүдийн худалдан авах чадвар буурсан, эргэлтийн хөрөнгийн хомстолд орсон асуудлыг шийдвэрлэх ажлын хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн 311 дүгээр тогтоолоор Газрын тосны бүтээгдэхүүний компанийн нөөц бүрдүүлэх үүрэг хүлээсэн 28 аж ахуйн нэгжид шаардлагатай санхүүжилтийг дэлхийн зах зээл дээрх газрын тосны үнэ, ОХУ-аас ирүүлсэн 11 сарын хил үнийг үндэслэн нийт 762,575.97 сая төгрөгийн санхүүжилтийг хөнгөлттэй зээл хэлбэрээр олгохоор шийдвэрлэсэн. Нэмэлт санхүүжилт олгох ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулснаар шатахууны хангамж тогтворжиж, хомстол үүсэхгүй байх нөхцөл бүрдээд байна<br>Түүнчлэн Гол нэр төрлийн зарим бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомстлоос сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль 2022 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр батлагдсантай холбогдуулан тус хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2 дахь заалт, Засгийн газрын 2022 оны 160 дугаар тогтоолын дагуу УУХҮЯ болон Газрын тосны бүтээгдэхүүн импортлогч аж ахуйн нэгжтэй байгуулах Газрын тосны бүтээгдэхүүний нийлүүлэлт, үнийн тогтвортой байдлыг хангах талаарх хариуцлагын гэрээний төслийг УУХҮСайдын 2022.05.12-ны өдрийн А/102 дугаар тушаалаар батлуулсан. Батлагдсан загварын дагуу ААН-үүдтэй хариуцлагын гэрээг 2022.05.30-ны өдөр байгуулсан | |
| 56 | | 3.5. Экологийн өндөр ангилал бүхий Евро-5 стандартын шатахууны | 2020 - 2024 | | | Евро-5 стандартын шатахууны хэрэглээ 25 | 2022 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн байдлаар нийт 766,2 мянган тонн газрын тосны бүтээгдэхүүн, үүнээс 672,2 мянган тонн шатахуун импортолсон. Үүнд: дизелийн түлш 383 мян.тонн, автобензин 289,3 мян.тонн байгаагаас К5 /Евро-5/ стандартын шаардлагад нийцсэн автобензин 75621 тонн, | 90 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулна | | | | хувьд хүрсэн байна. | дизелийн түлш 70706 мянган тонн, бүгд 146327 тонн байгаа нь нийт импортолсон шатахууны 21 хувийг эзэлж байна.<br>Экологийн өндөр ангилал бүхий Евро-5 стандартын шатахууны хэрэглээг нэмэгдүүлэх ажлын хүрээнд автобензин дизель түлшинд ногдуулах онцгой албан татварын хэмжээг экологийн ангилалтай уялдуулан тогтоох талаар дэлгэрэнгүй тооцоо судалгаа, танилцуулга бэлтгэн УУХҮСайдын 2022.02.24-ний өдрийн 01/469 дүгээр албан бичгээр Сангийн сайдад хүргүүлсэн.<br>Мөн Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооноос ирүүлсэн хүсэлтийн дагуу Евро 5 стандартын шаардлага хангасан автобензины импорт, үнийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл бэлтгэж, УУХҮ-ийн Дэд сайдын 2022.02.14-ний өдрийн 02/345 дугаар албан бичгээр Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороонд хүргүүлсэн.<br>Мөн 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр Агаарын тухай хуулийн 16-д Агаарын чанарыг сайжруулах бүсэд хориглох зүйлд /16.1.6/ "Монгол Улсын стандартаар тогтоосон экологийн хамгийн өндөр ангиллаас доош ангиллын, эсхүл уг ангиллын стандартын шаардлага хангаагүй автобензин, дизель түлшийг жижиглэнгээр худалдан борлуулах" гэж нэмэлт өөрчлөлт орсон | |
| 57 | | 3.6. Баруун бүсийн шатахууны хэрэглээний тодорхой хувийг хангах зорилгоор Ховд аймагт хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар бага оврын газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэр байгуулахад дэмжлэг үзүүлнэ. | 2020 - 2024 | УУХҮЯ,<br>АМГТГ | | ТЭЗҮ-г боловсруулж, батлуулсан байна. 20% | Ховд аймгийн Жаргалант сумын нутагт үйлдвэрийн зориулалтаар 6.0га газар эзэмших зөвшөөрөл авсан. Мөн төслийн Байгаль орчинд нөлөөлөх байдлын Ерөнхий болон Нарийвчилсан үнэлгээний тайланг мэргэжлийн байгууллагаар хийлгэж БОАЖЯ-ны Зөвлөлөөр хэлэлцүүлсэн. Үйлдвэрийн агуулахын зураг төсөл боловсруулж, аймгийн Мэргэжлийн хяналтын газар, ОБЕГ, БХБЯ-ны Барилгын хөгжлийн төвөөр тус тус батлуулсан. Гадаад талд үүсээд буй нөхцөл байдалтай холбоотойгоор төсөл хэрэгжүүлэгч компани ТЭЗҮ-д шаардлагатай зарим тодотголыг хийж байна. | 50 |
| 58 | | 3.7. Газрын тосны төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой | 2020 - 2024 | | | Газрын тосны судалгаа, шинжилгээ,хайгуул, ашиглалт, боловсруулалт | Газрын тосны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд төрийн өмчит компани байгуулах асуудлыг тусган оруулсан. | 30 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | компани байгуулах эрх зүйн орчин бүрдүүлэх ажлыг зохион байгуулж, Газрын тосны судалгаа, шинжилгээ, хайгуул, ашиглалт, боловсруулалт, хангамжийн цогц үйл ажиллагаа явуулах төрийн өмчит Үндэсний компани байгуулна | | | | , хангамжийн цогц үйл ажиллагаа явуулах төрийн өмчит Үндэсний компани байгуулах асуудлыг шийдвэрлэсэн байна. 20% | | |
| 59 | 3.5.2. Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжуулан Оросын Холбооны Улсаас Бүгд Найрамдах Хятад Ард Улс руу байгалийн хий дамжуулах хоолойн техник, эдийн засгийн үндэслэлийг дуусгаж, барилга угсралтын ажлыг эхлүүлэх бэлтгэл хангана. | 1. Монгол улсын газар нутгаар дайруулан татах хийн хоолойн судалгааг хийнэ. | 2021 - 2024 | Эрдэнэс Монгол ХХК, УУХҮЯ<br><br>ЭХЯ | | Судалгааны ажил үргэлжлэн хийгдэнэ | Хийн хоолойн ТЭЗҮ боловсруулах судалгааны ажлын хүрээнд трассын дагуу байрших ашигт малтмалын илрэл, тусгай зөвшөөрлийн талаарх мэдээллийг хүргүүлсэн. Судалгааны ажил дууссан бөгөөд ТЭЗҮ-ийг тусгай зориулалтын компани "Газопровод Союз Восток" ХХК 2021.12.15-ны өдөр монголын талд хүлээлгэн өгсөн.<br>2022 оны 2 дугаар сарын 28-ны өдөр Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан болон "Газпром" НХН-ийн Удирдах зөвлөлийн орлогч дарга В.А.Маркелов нар Монгол Улсын Засгийн газар болон "Газпром" НХН-ийн Хамтарсан ажлын хэсгийн 2022–2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж тус төлөвлөгөөний дагуу 2022.02.28-ны өдөр инженерийн хайгуул судалгаа, зураг төслийн ажлуудын даалгаврыг баталж "Газопровод Союз Восток" ХХК болон "Газпром Проектирование" ХХН-ийн хооронд инженер хайгуул судалгаа, зураг төслийн ажлуудыг гүйцэтгэх Гэрээнд гарын үсэн зурсан. Үүний дагуу 2022.04.28-ны өдөр инженерийн хайгуул судалгааны ажил эхэлж, судалгааны ажил хэвийн явагдаж байна. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 60 | 3.6.3. Зорилт | 2.1. Цахилгаан болон байгалийн хийн хөдөлгүүртэй тээврийн хэрэгслийн цэнэглэх сүлжээг ШТС, үйлчилгээний газруудыг түшиглэн төр хувийн хэвшлийн түншлэлээр байгуулна. | 2021 - 2024 | ЗТХЯ, УУХҮЯ<br><br>ТХААГ, ХХ | | Цахилгаанаар цэнэглэх 12 цэг, хийгээр цэнэглэх 6 станц | Байгалийн хийн импорт, борлуулалтын үйл ажиллагаа эрхлэгч "Юу Би Метан" ХХК нь 2021 онд 1000 тонн шахсан байгалийн хий импортлон, нийслэлийн нийтийн тээврийн 100 орчим хийн хөдөлгүүртэй автобусыг цэнэглэх үйл ажиллагаа явуулсан.<br>Тус компани 2021 онд Баянзүрх дүүргийн Монелд тээврийн хэрэгслийг байгалийн хий, ШШХ, шатахуунаар цэнэглэх станц барьж байгуулахаар зураг, төслийг батлуулан, эхний хэсгийг УОК-т хүлээлгэн өгсөн. Мөн Сонгинохайрхан дүүргийн Рашаант өртөөнд байгалийн хийн агуулах, хий цэнэглэх станц барих төслийг хэрэгжүүлж, барилга байгууламжийн ажлын гүйцэтгэл 80 гаруй хувьтай явагдаж байна. | 70 |
| 61 | 3.7.13. Барилгын үйлдвэрлэлд хэрэглэгдэх цемент, арматур, хавтгай шил зэрэг үндсэн нэр төрлийн материалыг эх орны эрдэс, түүхий эдээр дотооддоо үйлдвэрлэх замаар импортыг бууруулах бодлогыг хэрэгжүүлнэ. | 1. Эрдэнэтийн гангийн үйлдвэрийн тоног төхөөрөмжийг шинэчилж, үйлдвэрлэлийн үйл ажиллагааг жигдэрүүлнэ. | 2020 - 2024 | Хувийн хэвшэл,<br><br>БХБЯ, УУХҮЯ, | 132470.6 сая төгрөг ТӨҮГ-ын хөрөнгөөр | Барилга ажлыг бүрэн дуусгаж, тоног төхөөрөмж суурилуулсан байна. | "Бэрэн групп" ХХК-ийн 2014 оноос Орхон аймагт хэрэгжүүлж байгаа 200 мян.тн/жил хүчин чадалтай ган бүтээгдэхүүний үйлдвэрийн төслийн хэрэгжилт 75 орчим хувьтай байна. Тус компани нь Хөгжлийн банкнаас 2014 онд 22.7 сая ам.доллар, 2018 онд 4.5 сая ам.доллар, нийт 27.2 сая ам.долларын зээлийн санхүүжилт авсан ба үйлдвэр ашиглалтад орж үйл ажиллагаа эхлүүлээгүйн улмаас уг зээл эргэн төлөгдөөгүй байна. Цаашид үйлдвэрийг ашиглалтанд оруулахад шаардагдах 30.7 тэрбум төгрөгийн санхүүжилтийг нэмж олгох хүсэлтийг тус компаниас Хөгжлийн банк болон УУХҮЯ-нд гаргасан ба УУХҮЯ болон Хөгжлийн банкны зүгээс боломжит хувилбарыг судалж байна.<br>ХҮБГ-аас 2022 онд төслийн талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ: 2022.01.04-ны өдөр УУХҮСайдад "Бэрэн групп" ХХК-ийн Орхон аймагт хэрэгжүүлж байгаа "Эрдэнэтийн төмөрлөгийн үйлдвэр"-ийн төслийн явц, тулгамдаж байгаа асуудлын талаар тус компанийн захирал Б.Мөнхтөр танилцуулсан. УУХҮСайдаас үйлдвэрийг ашиглалтад оруулах календарчилсан төлөвлөгөө гарган шахуу тооцоотой ажиллаж үйлдвэрийг яаралтай ашиглалтад оруулах үүрэг даалгавар өгсөн.<br>Дээрх ажлын хүрээнд тус төсийн санхүүжилтыг шийдвэрлэх, үйлдвэрийг ашиглалтад оруулах асуудлаар Хөгжлийн банкны холбогдох удирдлагуудтай удаа дараагийн уулзалтуудыг ХҮБГ-аас зохион байгуулан төслийн санхүүжилтийг шийдвэрлэхээр ажиллаж байна. | 30 |
| 62 | | 2. Барилгын хавтгай шилний үйлдвэр | 2020 - 2024 | Хувийн хэвшэл, | | Шилний үйлдвэр барих төсөл боловсруулж | "Эрдэс плазм" ХХК-ийн шилний үйлдвэрийг дэмжин ажиллах бодлогын хүрээнд Засгийн газрын 2021 оны 08 дугаар сарын 04-ний өдөр 227 дугаар тогтоолоор ҮТП-ын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 5 жилийн хугацаатай олгосон. | 50 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | байгуулж ашиглалтад оруулна. | | БХБЯ, УУХҮЯ, НЗДТГ | | холбогдох газарт хүргүүлнэ. | “Эрдэс плазма” ХХК одоогийн байдлаар үйлдвэрийн зураг төслийн ажилд 220 мянган ам.доллар зарцуулаад байгаа бөгөөд ажлын зургийг эцэслэн хийлгэхийн тулд үйлдвэрлэх бүтээгдэхүүний нэр төрөл, зах зээлийг тодорхойлох, томоохон худалдан авагчидтай хэлэлцээр байгуулах шаардлагатай байгаа тул хүлээгдэж байна.<br>Үндсэн түүхий эдийн нэг болох Налайхын Элстэйн цахиурын элсний ордын ТЭЗҮ-ийг 2022.03.22-ны өдөр УУХҮЯ-ны ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн дэмжигдсэн, мөн БО-ны нарийвчилсан үнэлгээний тайланг БОАЖЯ-ны БОҮ-ний комиссын хурлаар 2022.06.07-нд хэлэлцүүлэн батлуулсан. Энэ ордын ашиглалтад шаардлагатай байгаа цахилгаан эрчим хүчний Техникийн нөхцөл олгогдохгүй байгаатай холбогдуулан Техникийн нөхцөл олгоход дэмжлэг үзүүлэх тухай хүсэлтийг 2022.06.15-ны өдрийн 3/2885 тоотоор “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-д хүргүүлсэн. | |
| 63 | | 3. Баруун бүсэд Ховд-Эко цементийн үйлдвэрийг ашиглалтад оруулна. | 2020 - 2024 | Хувийн хэвшэл,<br><br>БХБЯ, УУХҮЯ, Ховд аймгийн ЗДТГ | | Цементийн үйлдвэрийн барилгын ажлыг үргэлжлүүлнэ. | Баруун бүсэд Ховд-Эко цементийн үйлдвэрийн төсөл хэрэгжүүлж буй “Вестерн Холд” ХХК-ийн цементийн үйлдвэрийн төсөлд шаардагдах тоног төхөөрөмжийн импортод ноогдох албан татварыг 2 жилийн хугацаагаар хойшлуулсан гэрээний хугацааг сунгах хүсэлтийг Сангийн яаманд 2021.01.18-ны өдрийн 1/250 тоотоор хүргүүлсэн.<br>- Ховд Эко цементийн үйлдвэр 2022 оны 10 дугаар сард эхний бүтээгдэхүүнээ гаргахаар төлөвлөн ажиллаж байна. Одоогийн байдлаар угсралтын ажил төлөвлөгөөний дагуу явагдаж байна. Үүнд:<br>1. Барилга угсралтын ажил 97,82%<br>2. Тоног төхөөрөмж угсралтын ажил 52.2%<br>3. Металл хийц угсралтын ажил 69.61%-тай байна. | 100 |
| 64 | | 4. Барилгын материалын түүхий эдийн орд, илэрцийн хайгуулыг эрчимжүүлж бүс нутгуудад үйлдвэр байгуулах түвшинд нөөц тогтоох хууль эрхзүйн орчныг бүрдүүлнэ. | 2021 - 2024 | УУХҮЯ Хамтрагч нь БХБЯ | | Ашигт малтмалын тухай хууль, Түгээмэл тархацтай ашигт малтмалын хуулийн хэрэгжилтийн байдалд судалгаа хийнэ. | Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 3.3-т заасны дагуу Засгийн газрын 2014 оны 222 дугаар тогтоолоор Авто зам, төмөр замын салбарт хэрэгжүүлэх зарим төсөл, хөтөлбөрт шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмалыг хайх, ашиглах тусгай журмыг хэрэгжүүлж байна. Түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг аж ахуйн нэгж байгууллага нь өөрийн хөрөнгөөр эрэл хайгуулын ажил хийж нөөц тайлан болон ТЭЗҮ-ийг боловсруулан УУХҮЯ-ны дэргэдэх ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн батлуулдаг. Ашигт малтмалын тухай хуулиар 210, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулиар орон нутаг нь 442 тусгай зөвшөөрөл олгосноос 211 тусгай зөвшөөрлийг цуцлаад байна. | 30 |
| | | ДӨРӨВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 65 | 4.2.5. Төрийн албан хаагчийн үйл ажиллагааг үнэлэхдээ ажлын гүйцэтгэл, үйлчлүүлэгчийн үнэлгээ, ёс зүй, сахилга хариуцлагыг шалгуур болгож, ёс зүйн зөрчил гаргасан төрийн алба хаагчид хүлээлгэх хариуцлагыг чангатгана. | 3. Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэмд өөрчлөлт оруулна. Төрийн албаны үнэт зүйл, зарчим, манлайллыг өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх талаар сургалт, сурталчилгааны =хөтөлбөрийг батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллана. | 2021 - 2024 | Яамд, ТАЗ, УАкадеми | | Дүрэмд өөрчлөлт оруулах саналыг холбогдох байгууллагад хүргүүлнэ. Төрийн албаны үнэт зүйл, зарчим, манлайллыг хангах талаарх сургалт, сурталчилгааны хөтөлбөрийг батлуулж, хэрэгжилтийг эхлүүлнэ. | Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2022 оны Сургалтын төлөвлөгөөг Төрийн нарийн бичгийн даргаар 2022 оны 02 дугаар сарын 14-нд батлуулсан. Тайлант оны хагас жилийн байдлаар нийт Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад 4, Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад 5, Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 3, Эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 2 албан хаагч, Бусад цаг үеийн шинжтэй мэргэшүүлэх сургалтуудад /Мерит төслийн шугамаар болон ЖҮХ, ХЭҮК, ТАЗ, АТГ/ давхардсан тоогоор нийт 12 албан хаагчийг сургалтад хамруулсан байна. Мөн Сургалтын төлбөрийн буцалтгүй тусламж, тэтгэлгийн зардлын 2022 оны төлөвлөгөөг АМГТГ-аас ирүүлсэн саналын дагуу Төрийн нарийн бичгийн даргаар батлуулсан. | 100 |
| 66 | 4.3.17. Газрын тосны бүтээгдэхүүн, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн хадгалалт, хамгаалалт, тээвэрлэлтийн үеийн аюулгүй байдал, хяналтыг сайжруулна. | 1. Газрын тосны бүтээгдэхүүн, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн хадгалалт, хамгаалалт, тээвэрлэлтийн үеийн аюулгүй байдал, хяналтыг сайжруулна. | 2020 - 2022 | УУХҮЯ<br><br>Хамтрагч нь МХЕГ | | Газрын тосны бүтээгдэхүүн, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн хадгалалт, хамгаалалт, тээвэрлэлтийн үеийн аюулгүй байдал, хяналтыг сайжруулна. | Улсын Их Хурал 2020 оны 1 дүгээр сарын 30-ны өдөр Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийг баталсан. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн хадгалалт, хамгаалалт, тээвэрлэлтийн үеийн аюулгүй байдал, хяналтыг сайжруулах ажлын хүрээнд Засгийн газрын 2019 оны 313 дугаар тогтоолоор батлагдсан "Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм"-д 2020 оны 174 дүгээр тогтоолоор нэмэлт, өөрчлөлт оруулж батлуулсан.<br>Мөн МХЕГ, ЦЕГ-ын дарга нарын 2022 оны хамтарсан А/68, А/11 тушаалаар баталсан "Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн тээвэрлэлтийн аюулгүй ажиллагааны журам"-ыг мөрдүүлэн ажиллаж байна.<br>Газрын тосны бүтээгдэхүүнийг хадгалах агуулахад тавигдах шаардлага, хадгалах үеийн аюулгүй байдалтай холбоотой харилцааг Дэд бүтцийн сайдын 2004.05.19-ний өдрийн 96 дугаар тушаалаар баталсан "Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүний агуулах, галын аюулгүйн норм", Үйлдвэр худалдааны сайд болон Шадар сайд нарын 2007.05.07-ны өдрийн 90/12 дугаар тушаалаар баталсан "Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүнийг хадгалах зориулалтын савыг | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | улсын бүртгэлд бүртгэх журам"-аар тус тус зохицуулж байна. Мөн Газрын тосны бүтээгдэхүүн нь MNS 4978:2000 стандартаар аюултай ачаанд тооцогддог бөгөөд тээвэрлэлтийг Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2009 оны 188 дугаар тушаалаар баталсан "Автотээврийн хэрэгслээр хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд аюул, хохирол учруулж болзошгүй ачаа тээвэрлэх журам"-ийг дагуу гүйцэтгэдэг. АМГТГ нь газар дээрх дүрэм, журмын хүрээнд газрын тосны бүтээгдэхүүний хадгалалт, тээвэрлэлтийн үеийн аюулгүй байдалд холбогдох байгууллагуудтай хамтран тухай бүр хяналт тавьж ажиллаж байна. | |
| 67 | 4.5.5. Америкийн Нэгдсэн Улс, Япон, Европын Холбоо, Энэтхэг, Бүгд Найрамдах Солонгос Улс, Турк зэрэг өрнө, дорнын улс, холбоотой "гуравдагч хөрш"-ийн бодлогын хүрээнд түншлэлийн харилцааг өргөжүүлэн, эдийн засгийн хамтын ажиллагааг бэхжүүлж, бусад улстай харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэх чиглэлээр | 4. БНЭУ-тай Стратегийн түншлэлийг улам бэхжүүлж, БНЭУ-ын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж буй Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах төслийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. | 2021 - 2024 | УУХҮЯ, СЯ<br><br>Хамтрагч ГХЯ | | Үйлдвэрийг барьж байгуулахаар хэрэгжүүлж буй төсөлд тодорхой ахиц гарсан байна. | Газрын тос боловсруулах үйлдвэрийн инженерчлэл, зураг төсөл боловсруулах ажлын хүрээнд технологийн зарим байгууламжийн барилга угсралтын ажлын ерөнхий гүйцэтгэгчийн урьдчилсан сонгон шалгаруулалт болон гүн боловсруулалтын технологийн лиценз эзэмшигчдийг сонгох ажлууд дуусах шатанд байна. Уг ажлуудыг төслийн менежментийн зөвлөх БНЭУ-ын Engineers India Limited компанитай хамтран гүйцэтгж байгаа ба зөвлөхөөр буюу "Захиалагчийн инженер"-ээр Итали улсын "Prometheus" компани ажиллаж байна. Үйлдвэрийн технологийн бус барилга байгууламжын ажил /EPC-1/-ыг гүйцэтгэх Энэтхэгийн JMC Projects India компанийг шалгаруулж, 2020.10.13-ны өдөр гэрээг байгуулан барилга угсралтын ажлыг эхлүүлээд байна. бэлтгэлийг хангаж байна. Уг гэрээ байгуулснаар үйлдвэр барих төсөл төлөвлөлтөөс бүтээн байгуулалтын үе шатанд шилжиж байна. Мөн Газрын тос боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалтыг БНЭУ-ын Гадаад хэргийн яам, Эксим банк, Төслийн менежментийн зөвлөх /ТМЗ/ компанитай зөвшилцсөний үндсэн дээр үндсэн 4 хэсэгт хуваан хэрэгжүүлж байгаа ба эдгээрт:<br>EPC-1: Технологийн бус барилга байгууламж<br>EPC-2: Анхдагч процессийн болон дагалдах байгууламж<br>EPC-3: Үйлдвэрийн цахилгаан станц<br>EPC-4: Лицензит технологийн байгууламж<br>Тайлбар: (EPC: Инженерчлэл-худалдан авалт-барилга-угсралт)<br>Одоогийн байдлаар үйлдвэрийн барилга-угсралтын ажлын ерөнхий гүйцэтгэгчид болон гүн боловсруулалтын технологийн лиценз эзэмшигчдийг сонгон шалгаруулах ажил хийгдэж байгаа бөгөөд технологийн бус барилга байгууламжийн барилга-угсралтын ажил эхлээд байна | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | идэвхтэй ажиллана. | | | | | | | |
| | | ТАВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО | | | | | | |
| 68 | 5.1.8. Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрч, олон жил орхигдсон 8 мянган га талбайг нөхөн сэргээнэ. | 1. Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газрыг нөхөн сэргээнэ. | 2020 - 2024 | УУХҮЯ, АНЗДТГ, БОАЖЯ<br><br>МХЕГ | 84,0 сая төгрөгөөр Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт | Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн 2000 га талбайд нөхөн сэргээлт хийсэн байна. | Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуй нэгжүүдийн 2021 онд 2069,7 га-д техникийн нөхөн сэргээлт, 623.7 га-д биологийн нөхөн сэргээлт хийсэн байна. Ашигт малтмалын тухай хуулийн 48.6.3 дугаар заалтын дагуу 2022 оны уулын ажлын гүйцэтгэлийн тайланг 2023 оны 2-р сард ирүүлдэг. 2022 оны хагас жилийн мэдээлэл гаргах боломжгүй байна. | 70 |
| 69 | 5.1.12. Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох, бүтээмжтэй, хүртээмжтэй ногоон хөгжлийн бодлого хэрэгжүүлж, хүлэмжийн хийн ялгарлыг 12.3 хувиар бууруулна. | 2. Уур амьсгалын өөрчлөлтийн Парисын хэлэлцээрт оруулах үндэсний тодорхойлсон хувь нэмрийн хэрэгжилтийг хангана. | 2020 - 2024 | БОАЖЯ, ЭХЯ, БХБЯ, ЗТХЯ, СЯ, ХХААХҮЯ, УУХҮЯ<br><br>ОБЕГ, АНЗДТГ, ҮХГ | | Үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг хангуулна. | Уур амьсгалын өөрчлөлтийн Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх Монгол Улсын тодорхойлсон хувь нэмэр, зорилт арга хэмжээг тодорхойлох баримт бичгийг боловсруулах үүрэг бүхий Байгаль орчин аялал жуулчлалын сайдын тушаалаар байгуулагдсан Ажлын хэсэгт тус яамнаас холбогдох албан тушаалтнууд ажилласан болно. Ажлын хэсгээс Монгол Улсын хүлэмжийн хийн ялгарал нь дэлхийн нийт хүлэмжийн хийн ялгаралд өчүүхэн (0.09%) хувийг эзлэх боловч, нэг хүнд ноогдох хүлэмжийн хийн ялгарал нь дэлхийн дунджаас 2.7 дахин их байгааг тогтоосон. Мөн 2014 онд нийт 34482.73 мян.тн CO2 ялгаруулсны 50.08% нь эрчим хүч, 48.51% нь хөдөө аж ахуй, 0.95% нь аж үйлдвэр, үлдсэн 0.46 нь хог хаягдлын салбараас ялгарсан байна. Эрчим хүчний салбарын хүлэмжийн хийн ялгаралд 2020 онд нүүрсий олборлолт 4.9%-ийг эзэлж байна. Дээр дурдсан баримт бичгийг хэрэгжүүлэх арга хэмжээнд нүүрсний уурхайн метан хийг ашиглах асуудлыг 2025-2030 онд хэрэгжүүлэхээр тусгагдсан болно.<br>Монгол Улсын хэмжээнд 2022 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн байдлаар нийт 680,6 мянган тонн шатахуун импортлон хэрэглэснээс Евро-5 стандартын шатахуун 144,7 мянган тонн буюу нийт шатахууны 21,3 хувийг эзэлж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 55 хувиар өссөн үзүүлэлттэй байна.<br>Экологийн өндөр ангилал бүхий Евро-5 стандартын шатахууны хэрэглээг нэмэгдүүлэх ажлын хүрээнд автобензин дизель түлшинд ногдуулах онцгой албан татварын хэмжээг экологийн ангилалтай уялдуулан тогтоох талаар дэлгэрэнгүй тооцоо судалгаа, танилцуулга бэлтгэн Сангийн яаманд хүргүүлсэн. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр батлагдсан Агаарын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.6 дах хэсэгт “Монгол Улсын стандартаар тогтоосон экологийн хамгийн өндөр ангиллаас доош ангиллын, эсхүл уг ангиллын стандартын шаардлага хангаагүй автобензин, дизель түлшийг жижиглэнгээр худалдан борлуулах” гэж хориглох тухай нэмэлт орсон. Ийнхүү автотээврийн хэрэгслээс ялгаруулах агаарын бохирдлыг үр дүнтэй бууруулахын тулд Агаарын чанарыг сайжруулах бүсэд экологийн Евро-5 ангиллын стандартын шаардлагад хангаагүй шатахуун жижиглэнгээр худалдан, борлуулахыг хориглох эрх зүйн орчин бүрдсэн. | |
| **ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН** | | | | | | | | **60.58** |

2022.06.24

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР